

ГАРЧИГ

- 2–4 Бодлогын нийтлэл
- 5–7 Зохицуулалтын мэдээ
- 8–9 Байр суурь
- 10 Тайлбар ба зөвлөмж
- 11 Уур амьсгалын өөрчлөлт ба санхүүгийн тогтвортой байдал
- 12–13 2022 онд финтекийн салбарын нийт хөрөнгө оруулалт
- 14–21 Судлаачийн индэр
- 22–23 Компанийн засаглал, комплайнс
- 24–25 Санхүүгийн боловсрол
- 26–27 Олон улсын зах зээлийн мэдээ
- 28 Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

ИРГЭД, АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН САНХҮҮГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДААТГАГЧИЙН БАТАЛГААГААР ШИЙДВЭРЛЭХ БОЛОМЖ БҮРДЛЭЭ



Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Даатгалын тухай хуульд даатгагчийн баталгаа гаргах боломжийг бүрдүүлсэн зохицуулалтыг тусгаж, нэмэлт өөрчлөлт оруулсантай холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Н.Хүдэрчулуунтай ярилцлаа.

Юуны өмнө, даатгагч баталгаа гаргахтай холбоотой одоогийн зохицуулалт ямар байгаа талаар ярилцлагаа эхлүүлье?

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд тендерт оролцогч нь тендерийн баталгаа, гүйцэтгэлийн баталгаа болон урьдчилгаа төлбөрийн баталгааг зөвхөн банкны баталгаа, Засгийн газрын бонд, Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаас хэлбэрээр ирүүлэхээр тусгасан байдаг.

Гэхдээ бодит байдал дээр тендерийн үйл ажиллагаанд зөвхөн банкны баталгааг хүлээн зөвшөөрөх практик бий болоод байсан. Хуулийн дээрх зохицуулалт нь даатгагч нар баталгаа, батлан даалт гаргах боломжийг хязгаарлахаас гадна иргэд, аж ахуйн нэгжүүдийн хувьд мөнгөн хөрөнгөө банкинд баталгаа хэлбэрээр царцаан байршуулах зэрэг санхүүгийн дарамтыг үүсгэдэг байсан.

Тэгвэл дээрх асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор УИХ-аас 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Даатгалын тухай хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулиудад даатгагч нь баталгаа, батлан даалт гаргах боломжийг бүрдүүлсэн нэмэлт өөрчлөлтийг оруулсан. Ингэснээр орон сууцны ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийг даатгагчийн баталгаагаар шийдвэрлэх, төрийн худалдан авах ажиллагаанаас гадна аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн тендерт даатгагчийн баталгааг хүлээн авах боломжтой болсон болсон нь санхүүгийн салбарт, тэр дундаа даатгалын салбарт томоохон өсөлтийг авчрах хөшүүрэг болно гэж бид харж байна.

Үргэлжлэлийг 9-р нүүрт



ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

КРАУДФАНДИНГ

Краудфандинг гэдэг нь ихэвчлэн платформуор дамжуулан олон тооны хүмүүсээс мөнгө босгох замаар төсөл эсвэл бизнесийг санхүүжүүлэх технологи юм.



CROWDFUNDING

Crowdfunding is the technology of funding a project or venture by raising money from a large number of people, typically via the platform.

Эх сурвалж: Сэндбок зохицуулалтын орчны журам

БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

Монгол Улсын Их Хурлаас Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийг 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр баталж, хуулийн хэрэгжилтийг 2023 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хуульчилсан бөгөөд энэхүү хуулийн зорилго нь барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд, мөнгөн зээлийн үйл ажиллагааг байнга, ашиг олох зорилгоор эрхлэх иргэнийг бүртгэх, хяналт тавих, тэдгээрээс олгох зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоох, зээл, түүний хүүг төлөх болон мөнгөн зээлийн үйл ажиллагаанд үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулах юм.

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийг боловсруулах болсон үндэслэл, шаардлага нь Иргэний хуулийн 286 дугаар зүйлийн Барьцаалан зээлдүүлэх журмаар зээл олгох талаарх зохицуулалт болон Монгол Улсын стандарт MNS:5274-2017 “Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаанд тавих стандарт”-ын дагуу тус үйл ажиллагааг зохицуулж байгаа боловч хэрэгжилт хангалтгүй байгаа нь барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхлэгчдэд тавигдах шаардлага байхгүй, нэгдсэн бүртгэлгүй, эдгээр хууль болон стандартын хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий байгууллага нь тодорхойгүй

байгаатай холбоотой тул мөнгөн зээлийн үйл ажиллагааны бүртгэл, зохицуулалт, хяналт, зохицуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх шаардлага бий болсон. Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулиар мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийг бүртгэлжүүлэхтэй холбоотой тавигдах шаардлагыг тодорхойлж, зээлийн, барьцааны болон батлан даалтын гэрээний ерөнхий загварыг хуулийн хүрээнд тодорхойлж өгсөн. Мөн барьцаа хөрөнгийг зээлдэгчтэй харилцан тохиролцож бодитой үнэлэх, Цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлийн улмаас алдагдсан эд зүйлсийн талаарх мэдээллийг агуулсан цахим мэдээллийн сантай байх, барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь цахим мэдээллийн санд бүртгэгдсэн эд зүйлсийг барьцаанд авахгүй байх, мөнгөн зээлийн үйл ажиллагаанд тавих хяналт, маргаан шийдвэрлэх зэрэг асуудлыг нарийвчлан тусгасан.

Монгол Улсад нийт 13372 барьцаалан зээлдүүлэх үйлчилгээний газар бүртгэлтэй байгаагаас Улаанбаатар хотод 11,122, орон нутагт 2,250 үйл ажиллагаа явуулж байна. Улаанбаатар хотод нийт барьцаалан зээлдүүлэх газрын 83 хувь, Орхон, Дархан-Уул, Өмнөговь, Дорнод, Дорноговь аймгуудад 100-аас дээш барьцаалан зээлдүүлэх газар бүртгэлтэй байна.



Энэхүү бүртгэлтэй барьцаалан зээлдүүлэх газрууд нь үсчин, зочид буудал, биллиард, авто засвар, худалдааны зуучлал зэрэг үйл ажиллагааны зөвшөөрлийг давхар эзэмшдэг байна. Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль хэрэгжиж эхэлснээр мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээр бүртгүүлсэн хуулийн этгээд нь өөр үйл ажиллагаа давхар эрхэлж болохгүй, зөвхөн мөнгөн зээлийн үйл ажиллагааг дагнан эрхэлнэ.

Мөн энэхүү хуулийн зохицуулалтаар мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогыг тодорхойлох, зохицуулах, холбогдох төрийн байгууллагуудын уялдааг хангах зорилго бүхий Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх орон тооны бус Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөл байгуулагдах бөгөөд энэхүү зөвлөл нь төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэх ба мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн үйл ажиллагаанд хэрэглэх зээлийн, барьцааны, батлан даалтын гэрээний ерөнхий загвар, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоох, зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох аргачлалыг батлах үүргийг хүлээсэн. Зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, ажиллах журмыг Санхүүгийн зохицуулах хороо батлах бөгөөд зөвлөлийн бүрэлдэхүүнд Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, санхүү, төсвийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн захиргааны байгууллага, цагдаагийн төв байгууллага,

Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчид болон салбарын эрдэмтэн, судлаачдын төлөөллийг оролцуулна.

Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд Зөвлөлөөс баталсан зээлийн хүүгийн дээд хэмжээг зөрчиж зээлийн гэрээ байгуулсан бол зээлийн хүүгийн дээд хэмжээнээс хэтэрсэн дүнгээр хүү авах эрхээ алдана. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээ нь үндсэн хүүгийн 20 хувиас хэтрэхгүй байхаар хуульд заасан. Иймд үйлчлүүлэгчид нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээ нь үндсэн хүүгийн 20 хувиас хэтэрсэн нөхцөлөөр зээл олгож байгаа мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хуулийн дагуу үйл ажиллагаа явуулахыг шаардах боломжтой юм.

Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс хамааран аймагт 100,000,000 (зуун сая) төгрөг ба түүнээс дээш, нийслэлд 300,000,000 (гурван зуун сая) төгрөг ба түүнээс дээш хэмжээний хувь нийлүүлсэн хөрөнгөтэй мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн хуулийн этгээд нь Санхүүгийн зохицуулах хороонд, харин иргэний мөнгөн хөрөнгийн хэмжээ, хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 10,000,000 (арван сая) төгрөг ба түүнээс дээш хэмжээний хувь нийлүүлсэн хөрөнгөтэй тохиолдолд тухайн аймаг, нийслэлийн Засаг даргад өргөдөл гаргаж бүртгүүлэхээр заасан.



Энэ хуулийн 18 дугаар зүйлийн 18.6–д Санхүүгийн зохицуулах хороо эсхүл аймаг, нийслэлийн Засаг даргад мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээр бүртгүүлээгүй иргэн байнга, ашиг олох зорилгоор хүү тогтоосон зээлийн гэрээ байгуулж, зээл олгосон бол хүү авах эрхээ алдахыг тодорхой заасан. Өөрөөр хэлбэл байнга ашиг олох зорилгоор мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй бүртгэлгүй этгээдээс зээл авсан иргэн зээлийн хүү төлөхгүй байж болох үндэслэл бүрдэж байна гэсэн үг юм. Ингэснээр мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээр бүртгүүлээгүй иргэн, хуулийн этгээд энэ үйл ажиллагааг эрхлэх боломжийг хязгаарлаж байгаа юм. Энэ зохицуулалтаар өдрийн зээл гэх мэт мөнгө хүүлэлтийн шинжтэй үйл ажиллагаа эрхэлж буй этгээдүүдийг хуулийн зохицуулалтад оруулах, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах боломжийг бүрдүүлсэн. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь зээлдэгчтэй зээлийн гэрээ байгуулахаас өмнө мөнгөн зээлийн үйл ажиллагааны нөхцөлүүдийг зээлдэгчид тодорхой танилцуулсны үндсэн дээр барьцаа хөрөнгийг харилцан тохиролцон үнэлж, зээлийн хүү, хугацааг гэрээнд тодорхой зааж гэрээг байгуулна.

Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь барьцааны зүйлийг зээлдэгчтэй харилцан тохиролцож бодитой үнэлнэ гэж хуульд заасан. Энэ хуулийн 16 дугаар зүйлийн 16.2–т “Цагдаагийн байгууллага гэмт хэрэг, зөрчлийн улмаас алдагдсан эд зүйлсийн талаарх мэдээллийг агуулсан цахим мэдээллийн сантай байх бөгөөд мэдээллийн санг ажиллуулахтай холбогдсон журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж заасан бөгөөд мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд энэ хуулийн 16.2–г заасан цахим мэдээллийн санд бүртгэгдсэн эд зүйлсийг барьцаанд авахыг хориглоно. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь дээр заасан сэжиг бүхий эд зүйлсийн талаар цагдаагийн байгууллагад даруй мэдэгдэх үүрэгтэй. Иймд мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдүүд нь Цагдаагийн ерөнхий газартай нягт уялдаа холбоотой хамтран ажиллаж дээрх мэдээллийн санд мэдээлэл нийлүүлснээр үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хулгайн гэмт хэргийг бууруулах юм.

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль хэрэгжиж эхэлснээр мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг санхүүгийн мэргэжлийн оролцогч болгон чадавхжуулах, үйлчилгээний стандартыг сайжруулах, үйлчлүүлэгчдийн эрхийг хамгаалах, иргэдийг өндөр хүүтэй

мөнгө хүүлэлтийн хохирогч болохоос сэргийлэх, хулгайн эд зүйлсийг барьцаалан зээл авах үйлдлийг бууруулж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, цаашлаад мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд чухал ач холбогдолтой юм.

Санхүүгийн зохицуулах хорооноос хуулиар олгосон үүргээ хэрэгжүүлэх зорилгоор “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийг бүртгэх, түүнд хяналт тавих журам”, “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд бүртгэлийн дэвтэр хөтлөх, тайлан, мэдээ ирүүлэх журам”, “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хувийн дугаар олгох журам”, “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн ажиллах журам”, “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд сургалт явуулах журам”–ын төслүүдийг боловсруулан олон нийтээс нээлттэй санал авахаар ажиллаж байна.

Хууль хэрэгжиж эхлэхтэй зэрэгцэн иргэдийн хувьд мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээс санхүүгийн үйлчилгээ авахдаа аймаг, нийслэлийн Засаг дарга эсхүл Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй эсэхийг шалгаж, зээлийн хугацаа, хүү, үйлчилгээний нөхцөлтэй сайтар танилцаж үйлчилгээ авах, харьяалах бүртгэх байгууллагад бүртгэлгүй иргэн, хуулийн этгээдээс санхүүгийн үйлчилгээ авахгүй байх нь аливаа үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх юм.

ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

МЭНДЧИЛГЭЭ



Санхүүгийн зах зээлийн хөгжлийн төлөө сэтгэл, зүтгэлээ зориулан ажилладаг нийт ажилтан, албан хаагч, хамтран ажилладаг мэргэжлийн холбоод, зохицуулалтын байгууллагууд, хөрөнгө оруулагч, даатгуулагч, харилцагч, үйлчлүүлэгч Та бүхэндээ XVII жарны “Үзэсгэлэн боллогч” хэмээх усан туулай жилийн хаврын тэргүүн сарын мэндийг дэвшүүлье.

Учран золгож буй “Үзэсгэлэн боллогч” хэмээх усан туулай жилд буянт буурлууд маань энх тунх, амар түвшин, идэр залуус нь ухаан хурц, амжилт бүтээл арвин, хүүхэд багачууд нь эрүүл саруул, эрдэм билигтэй элгээрээ энх амгалан, төрлөөрөө төвшин жаргалтай байж өлзийт жилийн ерөөл билиг хэлэлцэн, өвөг дээдсээ хүндэтгэн золгож, сар шинэдээ дэлгэр сайхан шинэлээрэй.

Монгол Улсын санхүүгийн зах зээл улам хүчирхэгжин бэхжиж, олон улсад өрсөлдөхүйц, эдийн засгаа тэтгэсэн, чанартай, хүртээмжтэй бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дүүрэн сайхан жил байхыг билэгдэн ерөөе.

“ЭКСПОРТОД ГАРГАХ НҮҮРСНИЙ НЭЭЛТТЭЙ ЦАХИМ АРИЛЖАА” УУЛЗАЛТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛЛОО

Засгийн газраас баталсан “Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам”-ын хүрээнд нүүрсний цахим арилжааг нээлттэй, ил тод, оролцогчдын тэгш эрхийг

хангасан байдлаар зохион байгуулж, зах зээлийн бодит үнэ



тогтоох, арилжааны мэдээллийг худалдагч, худалдан авагч, бусад оролцогчдод бодитой, үнэн зөв, шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК хамтран “Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжаа” сэдэвт уулзалт хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Уулзалт хэлэлцүүлгийг нээж Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга Х.Булгантуяа, Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал нар үг хэлсэн Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал хэлсэн үгэндээ “УИХ-аас ил тод хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлэх, эрдэс баялгийн бүтээгдэхүүний гадаад, дотоодын зах зээл дээрх борлуулалтыг нээлттэй, оновчтой, өндөр үр ашигтай, зах зээлийн зарчимд нийцсэн аргаар хийх, шударгаар үнэ тогтооход чиглэсэн бодлого, чиглэлүүдийг гарган ажиллаж байна. Энэ хүрээнд хийгдэж буй томоохон ажлын нэг бол Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг баталсан явдал юм. Уг хууль нь энэ оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхлэх бөгөөд өнөөдрийн байдлаар нүүрсний арилжааг Засгийн газраас өнгөрсөн оны 12 дугаар сард баталсан “Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам”-ын зохицуулалтын дагуу явуулж байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос “Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжаанд тавих хяналтын журам”-ыг өнгөрөгч сард Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамтай хамтран баталж экспортод гаргах нүүрсний цахим арилжаанд хяналт тавин ажиллаж байна. Ингэснээр уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа шударга, нээлттэй ил тод зохион байгуулагдах цаашлаад таваарын бирж үүсэн бий болоход чухал ач холбогдолтой” гэдгийг онцолсон юм.

Энэ удаагийн уулзалт хэлэлцүүлэгт 200 гаруй аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл биечлэн оролцсон бол цахимаар 80 гаруй аж ахуйн нэгжийн холбогдох ажилтнууд оролцож биржийн болон нүүрсний арилжаатай холбоотой дүрэм журам, заавар, дуудлага арилжаанд хэрхэн оролцох, гэрээ хэлцэл хэрхэн байгуулах, төлбөр тооцооны талаар дэлгэрэнгүй мэдээллийг авахын зэрэгцээ сонирхсон асуултдаа хариулт авлаа.

ДААТГАЛЫН БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ ХУРАЛДЛАА



Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Даатгалын бодлогын зөвлөлийн энэ оны эхний хурал боллоо. Хурлаар даатгалын салбарт хийгдэж буй онцлох болон энэ онд хэрэгжүүлэхээр төлөвлөөд буй ажлуудын талаар товч танилцуулж, санал солилцов. Түүнчлэн УИХ-аас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай болон Даатгалын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор СЗХ-ноос баталсан даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагаа, баталгаанд тавигдах шаардлага, түүнд хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг зохицуулсан журам мөн ипотекийн даатгалын олон улсын туршлага, зохицуулалтын орчин, холбогдох журамд оруулж буй нэмэлт, өөрчлөлтийн талаар тус тус мэдээлэл хүргэж, цаашид анхаарах асуудлын талаар хэлэлцлээ.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төлөөлөл бодлогын зөвлөлд ажилладаг бөгөөд УИХ-д өргөн баригдаад буй Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийн танилцуулгыг энэ үеэр мөн хийв. Уг хуулийн төсөл батлагдсанаар урт хугацааны даатгалын салбарын хөгжилд ихээхэн нөлөө үзүүлэх ач холбогдолтой тул хуулийн төслийг боловсронгуй болгох, хэрэгжилтийг хангах чиглэлд Санхүүгийн зохицуулах хороо болон салбарын оролцогчдын оролцоо өндөр байх талаар дурдлаа. Түүнчлэн бодлогын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн голлох асуудлын нэг нь олон нийтэд даатгалын боловсрол олгох чиглэлээр цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх явдал байв. Санхүүгийн зохицуулах хорооноос дээрх чиглэлээр тусгайлсан хөтөлбөр боловсруулах, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилд төрийн байгууллагууд, мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх санал санаачилга гаргасныг зөвлөлийн гишүүд дэмжиж, энэ чиглэлээр цаашид шат дараатай ажлуудыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллахаар боллоо.

"САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ"-Г БАТАЛЛАА

Засгийн газраас баталсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр”-ийг үр дүнтэй хэрэгжүүлэх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр урт хугацааны стратегийг төлөвлөх, холбогдох төрийн байгууллагуудын оролцоог тодорхойлох хүрээнд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлийн өнгөрсөн оны 12 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит хуралдаанаар “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г хэлэлцсэн. Уг төлөвлөгөөг Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар баталсан.

Санхүүгийн зохицуулах хорооны чиг үүрэг, зохицуулалтын салбарын тоо жил ирэх тусам нэмэгдэж буйтай холбоотойгоор дээрх төлөвлөгөөгөөр баталсан 194 ажлын 70 орчим хувийг дангаар болон төрийн бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хорооны энэ сарын 08-ны өдрийн ээлжит хуралдааны 54 дүгээр тогтоолоор “Санхүүгийн зохицуулах хорооноос Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2023–2030)”-г баталлаа. Энэхүү төлөвлөгөөг Монгол Улсын “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-тэй уялдуулан боловсруулсан бөгөөд 2023–2030 он хүртэл

үргэлжлэх хугацаанд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх, Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага буюу ФАТФ-аас тогтоосон техник хэрэгжилтийн 40 зөвлөмж, 11 шууд хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтийг хангах чиглэлээр холбогдох арга хэмжээнүүдийг тасралтгүй хэрэгжүүлэх юм.


ДААТГАЛЫН САЛБАРТ САНХҮҮГИЙН ШИНЭ ҮЙЛЧИЛГЭЭ НЭВТЭРЛЭЭ

УИХ-аас Даатгалын тухай хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиудад даатгагч нь холбогдох этгээдээс бусад этгээдэд баталгаа, батлан даалт гаргах, төрийн худалдан авах ажиллагаанд даатгагчийн баталгааг хүлээн авах боломжийг бүрдүүлсэн нэмэлт өөрчлөлтийг оруулж баталсан. Энэхүү нэмэлт өөрчлөлттэй холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хорооны ээлжит хуралдаанаар “Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааны журам”-ыг хэлэлцэж, баталлаа.

Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд, хувийн хэвшил болон олон улсын төсөл хөтөлбөрүүдийн хувьд тендерийн үйл ажиллагаандаа даатгагчийн баталгааг ашиглах болсноор иргэд, аж ахуйн нэгжүүдэд учирч буй санхүүгийн хүндрэлийг илүү эдийн засгийн үр өгөөжтэй байдлаар шийдвэрлэх, санхүүгийн салбарт зөв өрсөлдөөнийг бий болгох, мөнгөн урсгалын эргэлтийг нэмэгдүүлэх, даатгалын салбарын эрэлт нийлүүлэлтийг өсгөж, хамрах хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх боломж бүрдэж байна. Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагаа болон баталгаанд тавигдах шаардлага, түүнд хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг зохицуулсан дээрх журам батлагдсанаар даатгалын компаниуд баталгаа гаргах үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд санхүү, төлбөрийн чадвар, удирдлага, зохион байгуулалтын хувьд ямар шаардлага тавигдах, баталгааны дээд хязгаар буюу хэдий хэмжээний баталгааг гаргаж болох зэрэг асуудлыг тодорхой болгож өгсөн. Ингэснээр даатгалын компаниуд 70 орчим тэрбум төгрөгийн баталгааг гаргах боломжтой болсон бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу гаргаж буй нийт баталгааны 30 орчим хувийг даатгагчийн баталгаагаар хангуулах боломжийг бүрдүүлэх юм. Түүнчлэн, Даатгалын тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу

даатгалын компаниуд нь орон сууцны ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн тодорхой хувьд даатгагчийн баталгааг гаргах боломжтой болсон. Ингэснээр иргэдэд учирч буй санхүүгийн хүндрэлийг шийдвэрлэх, иргэдийн ипотекийн зээлд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх мөн бусад салбарын үйл ажиллагаанд дэмжлэг болох зэрэг нийгэм, эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх ач холбогдолтой.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ТОГТОЛЦООГ СИСТЕМИЙН ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН АРГААР БЭХЖҮҮЛЭХ ТАЛААР ХЭЛЭЛЦЛЭЭ



Компанийн засаглалын тогтолцоог үр дүнтэйгээр хэрэгжүүлэх нь аливаа байгууллагын урт хугацааны тогтвортой өсөлт, хөгжлийг хангахад чухал ач холбогдолтой. Үүнтэй холбогдуулж Санхүүгийн зохицуулах хороо, Залуу судлаачдыг дэмжих сан болон “Санхүүгийн боловсролын зангилаа” ТББ хамтран “ISO 37000 стандарт дээр суурилсан байгууллагын засаглалын тогтолцоог системийн инженерчлэлийн аргаар бэхжүүлэх нь” уулзалт, хэлэлцүүлгийг энэ сарын 01-ний өдөр зохион байгууллаа.

“Залуу судлаачдыг дэмжих сан” ТББ-ын тэргүүн Д.Жаргалсайхан энэ үеэр сэтгэлгээний алгоритм, системийн логик зураглал, байгууллагын нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх тохиргоо бүхий угсардаг загвар, компанийн засаглалын олон улсын стандартын шалгууруудыг системийн инженерчлэлийн аргаар хангах талаар танилцуулсан юм. Оролцогчдын зүгээс ISO 9001, ISO 37000 стандарт, Steward-Leadership болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс” зэрэг засаглалын баримт бичгүүдэд тусгагдсан шаардлагуудыг шийдвэрлэхэд дижитал платформыг хэрхэн ашиглах мөн цаашид хамтран хэрэгжүүлэх шаардлагатай сургалт, судалгаа, шинжилгээний талаар санал солилцож, хэлэлцүүлэг өрнүүлэв.



БАЙР СУУРЬ

ИРГЭД, АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН САНХҮҮГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДААТГАГЧИЙН БАТАЛГААГААР ШИЙДВЭРЛЭХ БОЛОМЖ БҮРДЛЭЭ

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Даатгалын тухай хуулиудад даатгагчийн баталгаа гаргах боломжийг бүрдүүлсэн зохицуулалтыг тусгаж, нэмэлт өөрчлөлт оруулсантай холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Н.Хүдэрчулуунтай ярилцлаа.

Эхлэл нь 1-р нүүрт



Дээрх хуулиудад оруулсан нэмэлт, өөрчлөлт нь санхүүгийн салбарт томоохон өсөлт, хөгжлийг авчирна гэж байна. Энэ талаар товч танилцуулахгүй юу. Тэр дундаа даатгалын салбарт ямар, ямар өөрчлөлтийг авчирна гэж харж байна вэ?

Өнөөдрийн байдлаар даатгалын салбар нь санхүүгийн нийт салбарын 2 хүрэхгүй хувийг эзэлж байна. Ийм учраас даатгалын салбарт салхи оруулж, салбарын өсөлтийг бий болгоход дэмжлэг үзүүлэх шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ шаардлагатай байгаа энэ үед уг зохицуулалтыг бий болгосон нь даатгалын зах зээлийг өргөжүүлэн тэлэх цаашилбал улс орны эдийн засгийн хөгжилд томоохон түлхэц болох боломжийг бүрдүүлж байна. Тухайлбал даатгалын салбарын үйлчилгээний эрэлт, нийлүүлэлтийг өсгөх, салбарын хамрах хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх, эрсдэлийн удирдлага, санхүүгийн чадамжийг дээшлүүлэх ач холбогдолтой. Үүний зэрэгцээ иргэд, хувийн хэвшлийнхний санхүүгийн хүндрэлийг эдийн засгийн үр өгөөжтэй байдлаар шийдвэрлэх, санхүүгийн салбарт зөв өрсөлдөөнийг бий болгох, мөнгөн урсгалын эргэлтийг нэмэгдүүлэх улмаар олон тулгуурт санхүүгийн зах зээл, эдийн засгийг дэмжсэн бодлого, эрх зүйн хувьд чухал үр нөлөөтэй алхам болсон.

Даатгалын салбарт санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болсноор салбарын мэргэжилтэн, боловсон хүчнийг

чадавхжуулах, холбогдох мэдээллийн санг бүрдүүлэх гээд нэлээдгүй шаардлага зах зээл дээр бий болж байгаа бөгөөд энэ нь салбарын дэд бүтэц, хөгжлийг дараагийн шатанд авчрах хөшүүрэг болно. Нөгөөтээгүүр жижиг, дунд бизнес эрхлэгчдийн ч санхүүгийн хүндрэл, бэрхшээлийг даван туулах боломжийг бүрдүүлж чадсан гэдгийг онцлох нь зүйтэй.

Иргэд болон жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хувьд яг ямар давуу тал бий болж байна вэ?

Төрийн худалдан авах ажиллагааны газраас энэ онд зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад нийт 3.1 их наяд төгрөгийн буюу оны эхний хагас жилийн байдлаарх ДНБ-ний 13.5 хувьтай тэнцэхүйц 717 төсөл, арга хэмжээг төсвийн ерөнхийлөн захирагчид хэрэгжүүлэхээр тусгасан. Мөн хууль санаачлагчдын хийсэн судалгаагаар сүүлийн 5 жилд хувийн хэвшлийнхэн болон аж ахуйн нэгжүүд 2.3 их наяд төгрөгийг банканд баталгаа хэлбэрээр хүүгүйгээр байршуулан царцааж байна гэдгийг онцолж байсан. Эдгээр баталгаа нь хувийн хэвшлийнхэнд гол бэрхшээл болж байсан. Харин даатгалын компаниуд баталгаа гаргаж эхэлснээр иргэд, хувийн хэвшлийнхэнд учрах санхүүгийн хүндрэл, бэрхшээлүүд илүү хямд, амар байдлаар шийдвэрлэгдэх боломжтой болно. Мөн хуулийн төсөлд орсон бас нэг чухал заалт бол орон сууцны ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийг даатгагчийн баталгаагаар гаргах боломжийг бүрдүүлсэн явдал юм. Одоогийн байдлаар 20 гаруй мянган иргэн ипотекийн зээлд хамрагдахаар хүсэлтээ өгөөд байгаа талаар мэдээлэл байна. Иргэдийн хувьд ипотекийн зээлд хамрагдахын тулд банканд 20–30 хувийн урьдчилгаа төлдөг бөгөөд хүсэлт гаргасан айл, өрх бүр энэ мөнгийг нэг дор төлөх боломж тэр бүр байхгүй. Иймд энэ хэрэгцээг даатгалын баталгаагаар хангуулснаар иргэдэд учрах санхүүгийн хүндрэлийг шийдвэрлэх, ипотекийн зээлд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх үүнтэй холбоотой бусад салбарын үйл ажиллагаанд дэмжлэг болох зэрэг нийгэм, эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх ач холбогдолтой.

Эдгээр зохицуулалттай холбоотой оролцогч талуудын зүгээс ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ?

Даатгалын тухай хуульд даатгагч баталгаа гаргах талаарх зохицуулалтыг тусгахдаа уг харилцааг зохицуулсан журмыг Санхүүгийн зохицуулах хорооноос баталж, мөрдүүлэхээр заасан. Иймд даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагаа болон баталгаанд тавих шаардлага, түүнд хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг зохицуулсан “Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааны журам”-ыг батлаад байна. Ингэснээр даатгалын компаниуд баталгаа гаргах үйл ажиллагаа эрхлэхдээ санхүү, төлбөрийн чадвар болоод удирдлага, зохион байгуулалтын хувьд ямар шаардлага тавигдах, хэдий хэмжээний баталгааг гаргаж болох, үүсч болзошгүй эрсдэлээс хэрхэн сэргийлэх зэрэг шаардлагуудыг тодорхой болгож өгсөн. Тодруулбал, даатгагч нарын баталгаа гаргах үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн орчин бүрэн бүрдсэн гэж хэлж болно. Бидний тооцоолсноор даатгалын компаниуд 70 орчим тэрбум төгрөгийн баталгаа гаргах боломжтой бөгөөд энэ нь нийт гаргаж буй баталгааны 30 орчим хувийг даатгагчийн баталгаагаар хангуулах боломжийг бүрдүүлж байна гэсэн үг юм.

Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагаа нь шинэ үйлчилгээ, үйл ажиллагаа бөгөөд баталгаатай холбоотой эрсдэлийг үнэлэх мэдээллийн сан, туршлага дутмаг. Мөн гэрээний үүрэг зөрчигдөх үед өндөр дүнтэй гэрээний төлбөрийг төлөх шаардлагууд бий болж, даатгагчийн санхүүгийн чадавхад тодорхой хэмжээгээр дарамт үүсэх, тэдний үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүсэж болзошгүй. Иймд даатгагчийн хувьд баталгаа гаргуулагч талын эрсдэлийг маш нарийн сайн тооцоолж, мэргэжлийн өндөр түвшинд буюу нарийн төлөвлөлт, судалгаа шинжилгээнд үндэслэн, мэдээллийн сан, мэргэшсэн боловсон хүчин, удирдлага зохион байгуулалт бүхий эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх зайлшгүй шаардлага бий болоод байна.

Даатгагч баталгаа гаргах нь өндөр эрсдэлийг дагуулдаг гэлээ. Даатгалын компаниуд энэ эрсдэлийг дааж чадах уу, ер нь энэ төрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд бэлэн үү?

Өмнө дурдсанчлан даатгагч баталгаа гаргаж эхэлснээр нэг талаасаа үйл ажиллагаа нь өргөжиж, салбарын нийгэм, эдийн засагт гүйцэтгэх үүрэг нэмэгдэх боломж бүрдэх ч нөгөө талаас даатгагчийн хүлээж авах эрсдэл тэр хэмжээгээр өсөх, даатгагчийн санхүүгийн чадавхад тодорхой хэмжээгээр дарамт үүсэх нөхцөл бүрдэхийг үгүйсгэхгүй. Гэхдээ бүх даатгагч энэ зах зээл рүү орно гэж байхгүй. Даатгагч өөрийн хөрөнгө, санхүүгийн чадвар, эрсдэл даах чадвартаа нийцүүлэн баталгаа гаргах эсэх шийдвэрийг гаргана. Өөрөөр хэлбэл, даатгалын компани тус бүрийн эрхэлж буй үйл ажиллагааны цар хүрээ, санхүүгийн болон хөрөнгийн чадвар гээд нөхцөл байдал нь бүгд ялгаатай учраас компани тус бүрийн хүлээж авах эрсдэлийн хэмжээ ялгаатай. Иймд өөрийн санхүүгийн чадавхаас давсан эрсдэлийн

хувьд нэг бол баталгаа гаргахаас татгалзах эсхүл төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг хангахын тулд өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх шаардлагатай болно. Үүнээс гадна хамтын даатгал, давхар даатгал болон бусад арга хэрэгслийг ашиглаж өөрийн хүлээж авсан эрсдэлийг шилжүүлэх бүрэн боломжтой. Өөрөөр хэлбэл, даатгагч нар хамтраад энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлбэл эрсдэлийг илүү бууруулах боломжтой. Тийм ч учраас, баталгаа гаргах үйл ажиллагаа эрхлэх даатгагч нарыг нэгдсэн зохион байгуулалт бүхий хамтын удирдлагын бүтцийг бий болгож ажиллах шаардлагыг журамд тусгаад байна. Даатгалын компаниуд хамтраад гэрээний нийтлэг загвараа гаргаж, нэг үнийн түвшинг барьж ажиллах бөгөөд даатгагчийн баталгаатай холбоотой мэдээллийн нэгдсэн сан, хамтын эрсдэлийн санг байгуулж ажиллах юм. Ингэснээр нэг талаас даатгалын компаниуд харилцагчаа таних, эрсдэлийн үнэлгээ хийх чиглэлээр хамтран ажиллаж эрсдэлээ бууруулах боломжтой. Нөгөө талаас иргэд, аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн үйлчилгээний зардал буурч, үйлчилгээг илүү амар хялбар байдлаар авах боломжтой болно. Нэмж хэлэхэд, хуулиудад оруулсан нэмэлт, өөрчлөлт нь өнгөрсөн сарын 31-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн бөгөөд хуулийн хэрэгжилтийг хангахад нэн шаардлагатай зохицуулалтын журмыг баталсан. Харин одоо даатгалын компаниуд нэгдсэн зохион байгуулалттайгаар хамтран ажиллаж, баталгаа гаргах үйл ажиллагааныхаа эхлэлийг зөв тавих л үлдээд байна.

Олон улсад даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлдэг бол...?

Манай улсын хувьд шинээр гарч ирж буй ойлголт бол бусад орны хувьд түгээмэл хэрэглэгддэг бөгөөд зөвхөн даатгалын салбарт төдийгүй санхүүгийн бусад салбартаа ч дэмжлэг үзүүлдэг үйл ажиллагаа юм. Тухайлбал, Солонгост 1970-аад оноос хойш даатгагч нар баталгаа гаргах үйл ажиллагаанд оролцож эхэлсэн бөгөөд бүтээгдэхүүн хөгжлийн төрөл бүрийн үе шатыг дамжин хөгжиж ирсэн байна. Өнөөдрийн байдлаар тус улсад баталгааны даатгалын үйл ажиллагааг нэг компанид төвлөрүүлэн, баталгааны даатгалын цогц үйлчилгээг нэг дороос үзүүлж байна. Үүнээс гадна Энэтхэг улсын хувьд Даатгалын зохицуулалт, хөгжлийн газраас даатгагчийн гаргах баталгааны онцлог шинж чанар болон тухайн үйл ажиллагааны эрсдэл, онцлогийг харгалзан баталгааны даатгалын бизнесийг зохицуулах, хөгжүүлэх зорилгоор холбогдох журмыг баталж, мөрдүүлж байна. Энэ мэтээр АНУ, Сингапур, Герман зэрэг олон улсын даатгалын салбарт даатгагчийн баталгааны зохицуулалтыг бий болгож, уг баталгаа нь салбартаа тодорхой үүргийг гүйцэтгэдэг.

ТАЙЛБАР БА ЗӨВЛӨМЖ

МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР БАНКНААС БУСАД МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭДЭД ЗАЙНЫ БОЛОН ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ЖУРМЫГ ШИНЭЧИЛЛЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн ээлжит хуралдааны 22 дугаар тогтоолоор “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ыг шинэчлэн баталлаа.

Шинэчилсэн найруулгаар журмын хамрах хүрээг өргөжүүлж Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуультай холбогдуулан Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлсэн.

Зайны хяналт шалгалтын 4 төрлийн арга хэлбэрийг тодорхойлж өгсөн бөгөөд технологийн хөгжил дэвшилтэй уялдуулан тусгайлсан программ хангамжийг ашиглах боломжийг бүрдүүлсэн. Түүнчлэн олон улсын сайн туршлагаас үзэхэд улс орнууд мэдээлэх үүрэгтэй этгээдийн эрсдэлийг 6 сараас 2 жилийн давтамжтай үнэлдэг тул Санхүүгийн зохицуулах хорооноос эрсдэлийг сар бүр үнэлэхээр байсныг хагас жил тутам болгон өөрчлөн найруулсан. Ингэхдээ бусад зохицуулалттай салбарын санхүүгийн тайлан ирүүлэх хугацаатай уялдуулан эрсдэлийн үнэлгээний асуулгыг 7 дугаар сарын 10-ны өдрийн дотор болон дараа оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд цахим хэлбэрээр ирүүлэхээр зохицуулсан.

Мөн мэдээлэх үүрэгтэй этгээд нь хууль, журмаар хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох зэрэг захиргааны арга хэмжээ, эсхүл зөрчлийн арга хэмжээг авах, гэмт хэргийн шинжтэй бол холбогдох хууль сахиулах байгууллагад шилжүүлэх талаар тусгасан бөгөөд ингэснээр хариуцлагын арга хэмжээг тодорхой болгосон.

БАНК БУС САНХҮҮГИЙН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН ТАЛААР



Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”-д 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 36 дугаар тогтоолоор финтек бүтээгдэхүүнд тавигдах шаардлагатай холбоотой өөрчлөлтийг орууллаа.

Тус журмын финтек бүтээгдэхүүнд тавигдаж байсан шаардлагын хүрээнд ББСБ нь дэвшилтэд технологид суурилсан зээлийн бүтээгдэхүүн гаргах тохиолдолд мэдээллийн технологийн хувьд MNS ISO/IEC 27001:2021 стандартыг хангасан мэдээллийн аюулгүй байдлын аудит болон кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийлгэх зохицуулалттай байсныг тусгай зөвшөөрөл эзэмшигч нь финтек зээлийн бүтээгдэхүүн гаргахад ISO/IEC 27001 стандартыг хангахаас гадна хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 2,500,000,000 (хоёр тэрбум таван зуун сая) төгрөг байхаар өөрчиллөө.

ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ



Уур амьсгалын өөрчлөлтийн талаар олон улс даяар анхаарал хандуулж түүнийг бууруулахад чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлээд нилээд хугацаа өнгөрчээ. Уур амьсгалын өөрчлөлт санхүүгийн зах зээлд гамшгийн болон шилжилтийн гэсэн хоёр төрлийн эрсдэлийг үүсгэдэг. Гамшгийн болон шилжилтийн эрсдэл юм. Санхүүгийн зах зээлд ажиллаж буй байгууллагуудын хувьд дээрх хоёр эрсдэл санхүүгийн тогтвортой байдлыг доголдуулах болсон.

Санхүүгийн зах зээлд нөлөөлөх уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл гэж юу вэ?



Гамшгийн эрсдэл нь хэт халалт, үер усны аюул, ган гачиг, зуд болон өсөн нэмэгдэж буй температурын түвшингээс улбаатай ба эрсдэл нь хоёр эх үүсвэрээс үүсдэг. Үүнд цаг агаарын дулаарал, далайн түвшний ус нэмэгдэх болсонтой холбоотой үргэлжилсэн гамшгийн эрсдэл бол нөгөө нь үер, хүчтэй шуурга, зэрэг байгалийн гамшгийн тохиолдох магадлал нэмэгдэх буюу хурц гамшгийн эрсдэл болно. Манай орны хувьд сүүлийн жилүүдэд газар хөдлөлтийн тохиолдол нэмэгдэж, зарим аймгуудад хүчтэй үер буух, ган, зуд зэрэг байгалийн үзэгдлүүд тохиолдож буй давтамж нэмэгдэж байна.



Шилжилтийн эрсдэл нь нүүрсхүчлийн хийг бууруулахтай холбоотой авч хэрэгжүүлж буй бодлого, инновац болон зах зээлийн хандлагаас шалтгаалан үүсдэг ба гурван эх үүсвэрээс үүдэлтэй. Нэгдүгээрт, хүлэмжийн хийн ялгаруулалт багатай эдийн засаг руу шилжих болсонтой холбоотой өрх гэр, компаниудын өртөг өсөж улмаар бодлогын эрсдэл үүсдэг. Хоёрдугаарт, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой инновацууд нь тодорхой хөрөнгүүдийг үнэгүйдүүлснээс үүдэлтэй технологийн эрсдэл шинээр бий болгодог. Гуравдугаарт, хөрөнгө оруулагч болон хэрэглэгчдийн байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ, санхүүжилтийг илүүд үзэх болсонтой холбоотой эрсдэл нэмэгдэж байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас үүсэх эрсдэлийг хэрхэн удирдах вэ?



Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас үүсэх эрсдэлийг тооцох хэрэгсэл чухал бөгөөд үүнд уур амьсгалын сценарь шинжилгээ болон стресс тестийн аргыг ашигладаг. Олон улсын валютын сангаас улсуудын санхүүгийн тогтвортой байдлын үнэлгээг хийхдээ уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийг үнэлж, санхүүгийн тогтвортой байдалд нөлөөлөх нөлөөллийг тооцдог болсон. Ийнхүү тооцоход стресс тест, мэдрэмжийн болон сценарь аргыг ашиглах шинжилгээг хийдэг.

Олон улсын валютын сангаас мөн уур амьсгалын өөрчлөлтөд санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, нүүрсхүчлийн хий багатай эдийн засгийг дэмжихэд бодлогын 7 арга хэмжээ авах зөвлөмжийг гаргасан. Үүнд:

- ◆ Уур амьсгалтай холбоотой макро-санхүүгийн бодлого;
- ◆ Санхүүгийн систем дэх уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг хамгийн бага түвшинд бууруулах бүтцийн шинэчлэл;
- ◆ Төв банк, санхүүгийн зохицуулагчид уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн үнэлгээг системийн хэмжээнд нэгтгэх;
- ◆ Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэлийг хянаж, зохицуулах;
- ◆ Төв банкны санхүүгийн тайланд тогтвортой байдлын асуудлыг тусгах;
- ◆ Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийг үнэлэхэд шаардлагатай өгөгдөл цуглуулах архитектур гаргах;
- ◆ Эдийн засгийн бусад салбаруудын тэнцвэрийг хангах замаар уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийг бууруулах тогтвортой санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх.

Английн төв банк нүүрсхүчлийн хийн ялгаралгүй эдийн засгийн тогтолцоо руу шилжихийг дэмжиж, санхүүгийн зах зээлийг уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлд уян хатан байх зорилго тавьж, түүний хүрээнд 5 зорилтыг тодорхойлсон.

Макро түвшинд Засгийн газрын хэмжээнд дээрх байдлаар бодлогын арга хэмжээ авч байгаа бол микро түвшинд санхүүгийн байгууллагууд харилцагчийн зээлийн эрсдэлийг үнэлэхдээ уур амьсгалын өөрчлөлтийн улмаас үүсэх хүчин зүйлсийг харгалзан үзэх шаардлага бий болсон. Ингэснээр санхүүгийн байгууллагууд эрсдэлийн үнэлгээний аргачлалдаа уур амьсгалын эрсдэлийг тооцох стресс тестийн аргыг нэмэх юм.


Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийг бууруулж, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангахад Төв банк, санхүүгийн зохицуулагч, санхүүгийн байгууллагууд хамтдаа тус эрсдэлийг үнэлж, хариу арга хэмжээ авснаар хэрэгжинэ.

ФИНТЕК БА РЕГТЕК

2022 ОНД ФИНТЕКИЙН САЛБАРЫН НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг олон улсын сүлжээ байгууллага болох KPMG-ээс гаргадаг “Pulse of Fintech” финтекийн салбарын тойм 2023 оны 01 дүгээр сард нийтлэгдсэн бөгөөд 2022 онд дэлхий даяар нийт 164.1 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтаар 6,006 удаагийн хэлцэл хийгдсэн байна. 2022 оны финтекийн салбарын үзүүлэлтүүд 2021 онд хүрсэн түвшнээсээ нилээд хэмжээгээр буурсан боловч түүнээс өмнөх жилүүдийн хөрөнгө оруулалт, хэлцлийн нийт дүнтэй харьцуулахад 3 дугаарт жагсаж байгаа юм.


Зураг. Дэлхийн финтекийн салбарын хөрөнгө оруулалтын нийт дүн, хэлцлийн тоо



Эх сурвалж: KPMG


Дэлхийн хэмжээнд 2022 оны эхний хагас жилд 1.0 тэрбум ам.доллоор дээш дүнтэй найман M&A /merge and acquisition/ хэлцэл хийгдсэн бөгөөд үүнд Австралид төвтэй Afterpay компанийг 27.9 тэрбум ам.доллоор худалдан авч нэгтгэсэн, мөн венчур капитал компаниуд болох Герман улсад төвтэй Trade Republic, Англи улсад төвтэй Checkout.com компанийн хэлцэл, PE /private equity/-ийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан АНУ-д төвтэй Genesis Digital Assets компаниудын хэлцэл хамаарч байна. 2022 оны сүүлийн хагас жилд мөн 1.0 тэрбум ам.доллоор дээш дүнтэй дөрвөн M&A хэлцэл хийгдсэн бөгөөд хамгийн том нь АНУ-д төвтэй Avalara 8.4 тэрбум ам.доллоор худалдан авсан. Венчур капиталын чиглэлээрх хамгийн том хэлцэл нь Швед улсад байрлах Klarna-ийн хийсэн 800.0 сая ам.долларын хэлцэл болсон байна. PE /private equity/ чиглэлээрх хамгийн том хэлцэл нь 250.0 сая ам.долларын үнэлгээтэй АНУ-д төвтэй Avant-ийн хэлцэл байжээ. Дэлхийн нийт финтекийн салбарын хөрөнгө оруулалт, хэлцлийн дүнг дараах гурван төрөлд ангилж байна.

Зураг. Дэлхийн финтекийн салбар дахь VC /venture capital/ хөрөнгө оруулалтын нийт дүн, хэлцлийн тоо




Эх сурвалж: KPMG

Зураг. Дэлхийн финтекийн салбар дахь M&A /merge and acquisition/ хөрөнгө оруулалтын нийт дүн, хэлцлийн тоо



Эх сурвалж: KPMG

Зураг. Дэлхийн финтекийн салбар дахь PE /private equity/ хөрөнгө оруулалтын нийт дүн, хэлцлийн тоо



Эх сурвалж: KPMG

2022 оны финтекийн салбарын чиг хандлага, онцлог дараах нөхцөл, байдалтай харагдаж байна. Үүнд:

- ◆ Финтек компаниуд технологи хөгжихийн хирээр дагаж мөрдөхөд улам бүр төвөгтэй болж байгаа зохицуулалтын орчныг хялбаршуулах зорилгоор регтекийн салбарт хийгдэх хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдсэн.
- ◆ Олон улсын хэмжээнд криптовалют болон крипто биржийн хөрөнгө оруулалтын хэмжээ буурах хандлага ажиглагдсан.
- ◆ Финтекийн компаниудыг банк, даатгал, хөрөнгө удирдлагын компаниудтай хамтын ажиллагааг сайжруулах шаардлага тулгарсан.
- ◆ Хөрөнгө оруулагчид 2021 оны финтекийн салбарын өсөлтийн үнэлгээ тогтворжихыг хүлээж байсны улмаас 2022 хэлцлийн тоо буурсан зэрэг үзүүлэлтүүд гарчээ.

Бизнес загварынхаа амьдрах чадвар, тогтвортой ашигт ажиллагааг бодитоор харуулж чаддаг финтекүүд болох regtech болон кибер аюулгүй байдал зэрэг салбарт цаашид хөрөнгө оруулалт нэмэгдэх төлөвтэй байна. Урт хугацааны хувьд дэлхий даяар санхүүгийн үйлчилгээний өөрчлөлт шинэчлэлт үргэлжилж, санхүүгийн үйлчилгээг бусад салбаруудад нэвтрүүлэхэд анхаарал хандуулж байгаа тул финтекийн хөрөнгө оруулалтын хэтийн төлөв нэлээд эерэг хэвээр байна гэж KPMG-ээс үзжээ.

СУДЛААЧИЙН ИНДЭР

БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ, СТАНДАРТ

/ХУРААНГУЙЛСАН/

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Гүйцэтгэсэн:

Санхүүгийн зохицуулах хорооны Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын ахлах референт Н.Нарантуяа
narantuya@frc.mn

Гишүүд: Санхүүгийн зохицуулах хорооны Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын албан хаагчид Б.Тэмүүжин, Б.Батцэцэг, С.Будбаяр, Х.Хурцбилэг

ХУРААНГУЙ

Энэхүү судалгаагаар биржийн бус зах зээлд арилжаалагддаг үнэт цаасны шалгуур, оролцогч талууд, дэд бүтэц, зохион байгуулалтын талаар судалж олон улсад явагдаж буй өнөөгийн байдлыг тодорхойлоход зорьсон.

УДИРТГАЛ

Биржийн бус зах зээл (ББЗЗ) нь бизнесээ өргөжүүлэх, үйл ажиллагаагаа сайжруулахад санхүүжилт шаардлагатай гарааны буюу жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан үнэт цаас арилжих шалгуур багатай бирж юм.

Монгол Улсын хувьд уг зах зээлийн эрхзүйн орчныг бүрдүүлээд, үйл ажиллагааг эхлүүлснээр нэг жилийн хугацаа өнгөрөөд байна. Энэ хугацаанд ББЗЗ дээр арилжих бондын арилжаа нэлээн идэвхтэй байна. 2022 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 54 үнэт цаас гаргагчийн 67 компанийн бонд гарсан бөгөөд 681.7 тэрбум төгрөгийн хөрөнгийн санхүүжилтийг босгоод байна. Түүнчлэн өнөөг хүртэл нэг төрлийн буюу өрийн бичгүүд л арилжигдсан ба хувьцаа болон бусад санхүүгийн хэрэгслүүд гараагүй.

Иймд тус зах зээлийн үйл ажиллагааг олон улс жишиг зарчмуудтай нийцүүлснээр хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх, арилжих бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл нэмэгдэх, зах зээлд танигдах зэрэг давуу талыг бий болгоно.

Олон улсын стандартад нийцсэн ББЗЗ-ийн талаар таван агуулгын хүрээнд судалсан болно. Үүнд: ББЗЗ-ийн эрхзүйн зохицуулалт, зохион байгуулалт, арилжих

бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах шаардлага, хөрөнгө оруулалтад оролцогч талууд болон дэд бүтэц багтсан болно.

БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛД ОРОЛЦОГЧИД ТАВИХ ШАЛГУУР, НӨХЦӨЛ

Биржийн бус зах зээл нь албан ёсны бус боловч, зохион байгуулалт сайтай, нэг болон хэд хэдэн дилерүүдийн төвлөрсөн арилжааны сүлжээ гэдгээрээ хөрөнгийн биржээс ялгаатай. Дилер нь үнэт цаасны үнэ тогтоох, худалдах, худалдан авах замаар зах зээлд оролцогчийн үүрэг гүйцэтгэдэг. Энэ нь бусад үйлчлүүлэгч, дилерүүдэд ижил үнэ санал болгоно гэсэн үг биш.

Дилерүүд нь биржийн бус зах зээлээс хэдийд ч гарч болдог боловч энэ нь хөрвөх чадвар алдагдах, зах зээлд оролцогчдын худалдах, худалдан авах чадварыг алдагдуулах эрсдэл дагуулдаг. Хөрөнгийн бирж дээр үнэт цаасны үнэ ханш ил тод байдаг тул хөрвөх чадвар сайтай байдаг. Харин биржийн бус зах зээл дээр ил тод байдал бага, дүрэм журам арай сул зохицуулалттай байдаг. 2007 онд АНУ-ын ипотекийн зах зээлд гарсан хямралын улмаас үүссэн бүх үнэт цаас болон санхүүгийн үүсмэл хэрэгсэл биржийн бус зах зээл дээр арилжаалагдсан.

Дилерүүд нь үнэ тогтоох, үнийн санал асуух, тохиролцохдоо утсаар, мэйлээр, мессежээр харилцдаг. Улмаар үнийн саналыг цахим мэдээллийн самбар дээр байршуулдаг боловч хүн бүр нэвтрэх боломжгүй байдаг.

Ерөнхийдөө биржийн бус зах зээлд үндсэн хоёр ангилал бий. Эхнийх нь үйлчлүүлэгчийн зах зээл буюу дилер болон хувь хүмүүс эсхүл хедж сан зэрэг мэргэжлийн хөрөнгө оруулагч хоорондын хоёр талт арилжааг хэлнэ. Дилерүүд ихэвчлэн үнэт цаас, санхүүгийн үүсмэл хэрэгсэл болон тэдгээрийг худалдаж авах, худалдахад бэлэн байгаа үнийг жагсаасан "дилерийн гүйлгээ" хэмээх их хэмжээний цахим мессежээр дамжуулан үйлчлүүлэгчидтэйгээ холбоо тогтоодог.


Харин хоёр дахь ангилал буюу дилер хоорондын зах зээл дээр дилерүүд бие биедээ үнийн санал тавин арилжаа хийдэг. Дилер, дилертэйгээ шууд холбогдох бөгөөд ингэснээр цаг алдалгүй хурдан шуурхай ажиллах боломжтой юм.

Биржийн бус зах зээлийн арилжаанд ихэвчлэн хамтын хөрөнгө оруулалтын сан, хедж сан зэрэг мэргэжлийн хөрөнгө оруулагчид оролцох хандлагатай байдаг. Гэсэн хэдий ч Колумбын их сургуулийн 2013 оны судалгаагаар нэгж хувьцааны үнэ 5.0 ам.доллараас бага Penny stocks буюу ЖДҮ эрхлэгчдийн хувьцааг жижиг хөрөнгө оруулагчид эзэмшдэг байна.

Биржийн бус зах зээл дээр томоохон мэргэжлийн хөрөнгө оруулагчдаас эхлээд жижиг хөрөнгө оруулагч зэрэг аль ч хөрөнгө оруулагчид бүртгэлтэй брокер дилерээр дамжуулан оролцож болно.

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ БОЛОН САНХҮҮГИЙН ХЭРЭГСЭЛД ТАВИГДДАГ ШААРДЛАГА

Энэхүү бүлэгт АНУ-ын биржийн бус зах зээлд оролцоход дотоодын болон гадаад компаниудад тавигдах шаардлагыг судалсан. Мөн харьцуулан судалж дүгнэлт гаргах зорилгоор АНУ-ын Нью-Йорк-ийн хөрөнгийн биржид дотоодын компаниуд бүртгэгдэхэд тавигдах ерөнхий шаардлагыг оруулсан. Дүгнэлтэд Нью-Йорк-ийн хөрөнгийн бирж болон ОТСQX примэйрийг харьцуулсан. ОТСQX примэйр нь АНУ-ын биржийн бус зах зээлийн хамгийн өндөр шаардлага бүхий самбар юм.



Биржийн бус зах зээлд үнэт цаас гаргагчдыг ОТСQX, ОТСQB, ОТС Pink гэсэн 3 өөр зах зээлд хуваадаг ба хоорондоо эрсдэлийн түвшингээр ялгаатай байдаг. Хамгийн өндөр шаардлагыг хангаж зах зээлд нэвтэрч чадсан компаниуд ОТСQX-д

ордог бол ОТСQX-ийн шаардлагыг хангаж чадаагүй компани нь ОТСQB-д ордог. ОТСQX-д Америкийн нэгдсэн улсын компани болон олон улсын компани орох шаардлагын хувьд ялгаатай байдаг ба дотор нь ОТС болон ОТС примэйр гэж хуваадаг.

ОТСQX-д АНУ-ын компаниуд ороход тавигдах шаардлага:

- ◆ Жилийн эсвэл улирлын эцсийн байдлаар нийт 2 сая ам.долларын хөрөнгөтэй байх;
- ◆ Хамгийн сүүлийн санхүүгийн жилийн эцсийн байдлаар дараах шаардлагын дор хаяж нэгийг нь хангасан байх:

- I. 2 сая ам.долларын орлоготой;
- II. 1 сая ам.долларын цэвэр биет хөрөнгөтэй;
- III. 500,000 ам.долларын цэвэр орлоготой;
- IV. олон нийтэд арилжигдсан үнэт цаасны зах зээлийн хэмжээ 5 сая доллар байх.

◆ Биржийн тухай хуулийн 3a51-1-д заасны дагуу дараахын аль нэгийг хангана:

- I. үнэт цаасаа санал болгох үнэ 5 ам.доллар ба түүнээс дээш;
- II. хэрэв компани нь дор хаяж гурван жил тасралтгүй үйл ажиллагаа явуулж байгаа бол 2 ам.сая долларын цэвэр биет хөрөнгөтэй байх, харин гурваас доош жил тасралтгүй үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд 5 сая ам.долларын цэвэр биет хөрөнгөтэй байх ба энэхүү шаардлага нь тайлант хугацааны төгсгөлд, эсвэл завсрын хөрөнгийн өсөлтийн үр дүнд хангагдаж болно;
- III. сүүлийн гурван жилд хамгийн багадаа 6 сая ам.долларын дундаж орлоготой байх.
 - Бүрхүүлийн компани байж болохгүй;
 - Дампуурах, дахин зохион байгуулагдах үйл ажиллагааны эрсдэлгүй байх;
 - Бизнесээ нээсэн муж бүртээ сайн байр суурьтай байх;
 - Тус бүр хамгийн багадаа нэг лот хувьцаа эзэмшдэг 50-аас доошгүй хувьцаа эзэмшигчтэй байх;
 - Компани ОТСQX-д орох хүсэлт гаргахаас өмнөх хуанлийн дараалсан 30 хоногийн хугацаанд

хувьцааны хаалтын үнэ хамгийн багадаа 0.1 ам.доллар байх.

ОТСQX–д олон улсын компаниуд ороход тавигдах шаардлага:

- ◆ Жилийн эсвэл улирлын эцсийн байдлаар нийт 2 сая ам.долларын хөрөнгөтэй байх;
- ◆ Хамгийн сүүлийн санхүүгийн жилийн эцсийн байдлаар дараах шаардлагын дор хаяж нэгийг нь хангасан байх:
 - I. 2 сая ам.долларын орлоготой;
 - II. 1 сая ам.долларын цэвэр биет хөрөнгөтэй;
 - III. 500,000 ам.долларын цэвэр орлоготой;
 дэлхийн зах зээлийн үнэлгээ 5 ам.сая доллар байх.
- ◆ Биржийн тухай хуулийн 3а51–1–д заасны дагуу дараахын аль нэгийг хангана:
 - I. үнэт цаасаа санал болгох үнэ 5 доллар ба түүнээс дээш;
 - II. хэрэв компани нь дор хаяж гурван жил тасралтгүй үйл ажиллагаа явуулж байгаа бол 2 сая ам.долларын цэвэр биет хөрөнгөтэй байх, харин гурваас доош жил тасралтгүй үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд 5 сая ам.долларын цэвэр биет хөрөнгөтэй байх;
 - III. сүүлийн гурван жилд хамгийн багадаа 6 сая ам.долларын дундаж орлоготой байх;
- ◆ Бүрхүүлийн компани байж болохгүй;
- ◆ Шаардлага хангасан гадаадын хөрөнгийн биржид хуанлийн 40–өөс доошгүй хоногийн өмнө үнэт цаасаа бүртгүүлсэн байх; хэрэв компани нь үнэт цаасаа шаардлага хангаагүй, АНУ–ын бус хөрөнгийн биржид бүртгүүлсэн тохиолдолд гүйцэтгэх албан тушаалтан, захирал, компанийн 10–аас дээш хувийн хувьцааг эзэмшигч бүрийн хувийн мэдээлэл болон ОТС маркет группэд шаардлага хангасан эсэх талаар шийдвэр гаргахад шаардлагатай гэж үзсэн бусад материалуудыг ирүүлж ОТСQX–д орох хүсэлтээ гаргаж болно.

ОТСQX примэйрт АНУ–ын компаниуд ороход тавигдах шаардлага:

- ◆ ОТСQX U.S–д ороход тавигдах бүх шаардлагыг хангасан байх;
- ◆ Олон нийт эзэмшдэг хувьцааны тоо хэмжээ хамгийн багадаа 500,000, эсхүл олон нийт эзэмшиж буй хувьцааны зах зээлийн үнэлгээ хамгийн багадаа 1 сая ам.доллар байх;
- ◆ Санхүүгийн сүүлийн жилд, эсвэл сүүлийн 3 жилийн хоёрт нь хамгийн багадаа 500,000 ам.долларын цэвэр орлоготой байх, эсхүл хувьцаа эзэмшигчдийн өмч

хамгийн багадаа 2.5 сая ам.доллар бүртгэлтэй үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 35 сая ам.доллар байх;

- ◆ Тус бүр хамгийн багадаа нэг лот хувьцаа эзэмшдэг 100–аас доошгүй хувьцаа эзэмшигчтэй байх;
- ◆ Компани ОТСQX–д орох хүсэлт гаргахаас өмнөх хуанлийн дараалсан 30 хоногийн хугацаанд хувьцааны хаалтын үнэ хамгийн багадаа 1 ам.доллар байх.

Компани нь санхүүгийн тайлангаа хувьцаа эзэмшигчдийн жилийн хурлыг хуралдуулахаас хуанлийн 15–аас доошгүй хоногийн өмнө хувьцаа эзэмшигчдэд хүргэх

ОТСQX примэйрт олон улсын компаниуд ороход тавигдах шаардлага:

- ◆ ОТСQX примэйрт ороход тавигдах бүх шаардлагыг хангасан байх;
- ◆ Сүүлийн санхүүгийн жилийн тайлангаар;
 - (a) 100 сая ам.долларын орлоготой байх;
 - (b) 500 сая ам.долларын дэлхийн зах зээлийн үнэлгээтэй байх;
 - (c) өмнөх 3 жилийн мөнгөн гүйлгээний нийт дүн 100 сая ам.доллар;
 - (d) өмнөх 2 жил тус бүрийн мөнгөн гүйлгээний доод хэмжээ 25 сая ам.доллар байх;
 Эсхүл, (a) 75 сая ам.долларын орлоготой;
- (b) 750 сая ам.долларын дэлхийн зах зээлийн үнэлгээтэй байх.

ОТСQV–д ороход тавигдах шаардлага:

- ◆ Хуанлийн сүүлийн 30 өдөр, өдөр бүрийн ОТС зах зээл дээрх хаалтын үнэ хамгийн багадаа 0.01 ам.доллар байх;
 - ◆ Хэрэв компани ОТСQX–ээс ОТСQV руу шилжсэн бол өмнөх хуанлийн 30 хоногийн дор хаяж нэгт нь хаалтын ханш 0.01 ам.доллар байх;
 - ◆ Дампуурах, дахин зохион байгуулагдах үйл ажиллагааны эрсдэлгүй байх;
 - ◆ Хууль тогтоомжийн дагуу сайн байр суурьтай байх;
 - ◆ Өргөдөл гаргах, өргөдлийн жилийн хураамжаа төлдөг байх;
 - ◆ ОТС вэбсайт дээр компанийн одоогийн, үнэн зөв мэдээллийг оруулдаг байх;
 - ◆ SEC–д бүртгэлтэй шилжүүлгийн агентыг ашиглаж ОТС зах зээлд компанийн хувьцааны талаарх (эргэлтэд байгаа хувьцаа, гаргасан хувьцаа, эрх бүхий хувьцаа, гаргасан түүх гэх мэт) мэдээллээр хангуулах;
- Компанийнхаа одоогийн танилцуулгыг үнэн зөв эсэхийг баталгаажуулж, хяналтын хувьцаа эзэмшигчид, захирал

болон мэргэжилтнүүдийн мэдээллийг агуулсан OTCQB жилийн гэрчилгээг ирүүлэх;



БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛДАГ БАЙГУУЛЛАГА

JASDAQ: Япон улсын хувьд биржийн бус зах зээлийн үйл ажиллагааг Японы үнэт цаасны дилерүүдийн автоматжсан холбоо (Japan Association of Securities Dealers Automated Quotation –JASDAQ) явуулдаг.

Японы Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо 1963 онд биржийн бус зах зээлийн платформор дамжуулан уг арилжааг хийж эхэлсэн. 1991 онд энэхүү системийг цахим зах зээлд шилжүүлж, 2004 онд JASDAQ үнэт цаасны бирж болон тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулах болсон. Улмаар Осакагийн хөрөнгийн бирж нь 2010 онд JASDAQ-ийг худалдаж авсан. 2013 онд Осакагийн хөрөнгийн бирж болон Токиогийн хөрөнгийн бирж (TSE) нэгдэж, Японы биржийн групп байгуулагдахад JASDAQ мөн нэгдсэн. Ингэснээр JASDAQ нь биржийн группийн дор охин компани хэлбэртэйгээр үйл ажиллагаа явуулдаг бие даасан компанийн түвшинд ажилладаг болсон.

Өнөөдөр JPX нь Нью-Йоркийн хөрөнгийн бирж болон NASDAQ-ын дараа дэлхийд гурав дахь том бирж юм.

Компаниуд Японы хөрөнгийн биржид бүртгүүлэхийн тулд хамгийн бага хувьцаа эзэмшигчдийн тоо, зах зээлийн үнэлгээ, цэвэр хөрөнгө, ажилласан жил зэрэг хэд хэдэн шалгуурыг хангасан байх ёстой. Анхны болон венчур шатны бизнесүүдэд анхаарлаа хандуулдаг тул JASDAQ-ийн жагсаалтад тавигдах шаардлагууд нь илүү тогтсон бизнесүүдийг зохион байгуулдаг Токиогийн хөрөнгийн биржээс илүү зөөлөн, уян хатан шаардлага тавьдаг.

NASDAQ (INDEXNASDAQ: .IXIC): АНУ-д National Association of Securities Dealers Automated Quotations (NASDAQ) нь Нью-

OTC Пинк-д ороход тавигдах шаардлага:

Хамгийн өндөр эрсдэлтэй үнэт цаасыг багтаасан OTC Пинк нь олон нийтэд нээлттэй болгосон мэдээллийн түвшинд үндэслэн одоогийн мэдээлэл, хязгаарлагдмал мэдээлэл, мэдээлэлгүй гэсэн гурван ангилалд хуваагддаг.

Йоркийн хөрөнгийн биржтэй харьцуулахуйц АНУ-ын томоохон хөрөнгийн бирж. Энэ нь хүмүүст үнэт цаасыг цахим хэлбэрээр худалдаж авах, зарах платформ ба ихэвчлэн хувьцаа хэлбэрээр байдаг.

1971 онд анх нэвтрүүлж байх үед NASDAQ-ийн зорилго нь компьютержсон системийг ашиглан хувьцааны арилжааг илүү хурдан, хүртээмжтэй болгох явдал байв. Гарааны бизнесүүдийн хувьд (ихэвчлэн технологийн компаниуд) NASDAQ-д бүртгүүлэх нь Нью-Йоркийн хөрөнгийн биржээс илүү хурдан хөрөнгө босгож, өсөх арга байсан.

Энэхүү шинэ загвар нь сонирхол татахуйц байсан, учир нь компаниуд хөрөнгийн зах зээлд гарах болсон шалтгаан нь бизнесээ эргүүлэн татахын тулд хөрөнгө босгох явдал юм. NASDAQ нь хөрөнгийн зах зээл дэх өрсөлдөөнийг бий болгосноор хөрөнгийн өсөлтийг дэмждэг.

NASDAQ-ийн бүрэлдэхүүн хэсгүүд:

NASDAQ нь арилжааны платформ ба индекс гэсэн хоёр бүрэлдэхүүн хэсэгтэй.

NASDAQ-ийн эхний бүрэлдэхүүн хэсэг болох арилжааны платформ нь арилжаа хийхдээ худалдан авагч болон худалдагчдын хүссэн үнийг тохируулах системийг ашигладаг.

Жишээлбэл, Apple-ийн 50 ширхэг хувьцааг нэг ширхгийг нь 295 ам.доллороор худалдаж авах хүсэлтэй худалдан авагч, тэр үнээр худалдахад бэлэн байгаа худалдагч байвал NASDAQ тохирох арилжааг гүйцэтгэдэг.

NASDAQ-ийн хоёр дахь бүрэлдэхүүн хэсэг болох индексийг "NASDAQ composite" гэж нэрлэдэг бөгөөд энэ нь Dow Jones

Industrial Average эсвэл S&P 500 зэрэгтэй адилхан жишиг индекс юм.

NASDAQ Composite-ийн зорилго нь биржийн ерөнхий гүйцэтгэлийг илэрхийлэх явдал юм.

NASDAQ нь тооцоололдоо олон төрлийн үнэт цаасыг ашигладаг бөгөөд үүнд NASDAQ-д бүртгэлтэй бүх хувьцаанууд байдаг бөгөөд тэдгээрийн дийлэнх нь технологийн салбарт байдаг.

Ерөнхийдөө NASDAQ нь Apple, Facebook, Amazon-ийн эх орон болох технологийн компаниудын зах зээлд гарах газар гэж ойлгогддог.

NASDAQ-ийн өөр хувилбарууд:

NASDAQ болон Нью-Йоркийн хөрөнгийн бирж нь Хойд Америкт арилжаалагддаг бүх үнэт цаасны дийлэнх хувийг бүрдүүлдэг.

NASDAQ гарч ирэх хүртэл худалдаачид Нью-Йоркийн хөрөнгийн биржийн Уолл Стрит дэх арилжааны талбай руу очиж худалдах, худалдан авах шаардлагатай болсон.

Нью-Йоркийн хөрөнгийн бирж нь дуудлага худалдаа маягийн хэлбэрээр худалдаачид хооронд нүүр тулсан харилцан тохиролцоонд тулгуурладаг бол NASDAQ нь брокероор дамжуулан дэлхий даяарх худалдан авагч, худалдагчдад арилжаа хийх боломжийг олгодог.

KOSDAQ: Солонгосын үнэт цаасны дилерүүдийн автоматжсан холбоо (Korea Securities Dealers Automated Quotations–KOSDAQ) нь 1996 онд байгуулагдсан Korea Exchange (KRX)-ийн хоёрдогч арилжааны зөвлөл юм. Анх Солонгосын Санхүүгийн Хөрөнгө Оруулалтын Нийгэмлэгээс Солонгосын Хөрөнгийн Биржээс бие даасан хөрөнгийн зах зээл болгон үүсгэн байгуулсан KOSDAQ нь Америкийн түнш NASDAQ-ийн загвараар хийгдсэн.

KOSDAQ бол NASDAQ шиг цахим хөрөнгийн зах зээл юм. Зах зээлийн нээлттэй цаг нь KST-ийн 09:00–15:00 цаг хүртэл байна.

KOSDAQ нь KRX-ийн ЖДҮ болон венчур зах зээлийг зохицуулах салбар хэлбэрээр ажиллаж байна. 2015 оны 02 дугаар сарын 9-ний өдрийн байдлаар KOSDAQ-д 1061 компани бүртгэлтэй байгаа бол KRX-ийн үнэт цаасны зах зээлд (KOSPI) 769 компани бүртгэлтэй байна.

Нөгөөтээгүүр, KONEX (Солонгосын Шинэ Бирж) бол KOSDAQ-

д бүртгүүлэхээс өмнө зөвхөн жижиг, дунд бизнес (ЖДҮ) болон венчур компаниудад зориулагдсан үйл ажиллагаа явуулдаг үнэт цаасны бирж юм. KONEX нь ЖДҮ болон венчур хөрөнгө оруулагчдад хөрөнгө босгох, хөрөнгө оруулалт татахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор байгуулагдсан бөгөөд 2013 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс үйл ажиллагаагаа эхэлсэн.

Одоогийн байдлаар KONEX портал дээр 71 компани бүртгэлтэй, i-KONEX нь зөвхөн Солонгос хэлээр үйл ажиллагаа явуулдаг.

1986 оны 7 дугаар сард Солонгосын Засгийн газар "Жижиг бизнест олон нийтэд арилжаалагдах хөрөнгийг идэвхжүүлэх зах зээлийн байгууллага" гэх бодлогын арга хэмжээг баталсан. Энэ нь жижиг, дунд бизнес эрхлэгчдэд нээлттэй хувьцаагаар дамжуулан хөрөнгө босгох, хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалтын шинэ чиглэл өгөх боломжийг олгох зорилготой байв. 1987 оны 4 дүгээр сард зах зээлийн зохион байгуулалтад хүрч, эхний гурван компани бүртгэгдсэн.

1996 оны 5 дугаар сард зах зээлийг эрчимжүүлэх, орчин үеийн болгох, бүрэн компьютержуулах зорилгоор KOSDAQ үнэт цаасны биржийг байгуулсан.

1997 онд Валютын хямралын үеэр KOSDAQ-ийн зах зээлийн индексүүд огцом унаж, хөрөнгө оруулагчид их хэмжээний хохирол амссан боловч Солонгосын эдийн засаг хурдан сэргэсний улмаас KOSDAQ-ын зах зээлийн үнэлгээ 2000-аад он хүртэл хурдацтай сэргэж, зах зээлийн үнэлгээ өссөн байна. 2001 онд KOSDAQ хороо нь Үнэт цаасны гүйлгээний тухай хууль дээр үндэслэн байгуулагдсан. Үүний дараа 2005 оны 01 дүгээр сард Үнэт цаас, фьючерсийн биржийн тухай хуулийн дагуу Солонгосын хөрөнгийн бирж, KOSDAQ, Солонгосын фьючерс бирж, KOSDAQ хорооноос бүрдсэн Солонгосын бирж (KRX) байгуулагдав. Мөн KOSDAQ зах зээлийн хороо нь KOSDAQ арилжааг хариуцдаг.

KOSDAQ-д бүртгэлтэй компаниудын холбоо нь KOSDAQ-д бүртгэлтэй бизнесүүдийг дэмжих, KOSDAQ-д бүртгэлтэй компаниудын ашиг тусын тулд бодлого, боловсролын хөтөлбөр боловсруулах зорилгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ДЭД БҮТЭЦ, ПРОГРАММ ХАНГАМЖ

Биржийн бус зах зээлийн дэд бүтцийн бүрэлдэхүүн:

- ◆ Төвлөрсөн тооцооны төв
- ◆ Бирж
- ◆ Электроник платформ
- ◆ Арилжааны сан: ил тод байдлыг нэмэгдүүлэх арга хэрэгсэл.

Төвлөрсөн тооцооны төв (ССР)

2009 Санхүүгийн хямралын дараа Их 20 орны удирдагчид уулзаж дэлхийн биржийн бус деривативын зах зээлийг шинэчилсэн. Үүний үр дүнд 2009 оны 9 дүгээр сард тус зах зээлд дериватив стандарт гэрээний (2009 Pittsburgh summit) дагуу бирж дээр арилжигдаж ССР-ээр дамжуулан тооцоо хийх болсон.

ССР нь холбоотой талуудын болон үйл ажиллагааны эрсдэлээс сэргийлдэг. Гэхдээ ССР нь эрсдэлийн удирдлага зарчим болон засаглалын сайн тогтолцоотой байснаар холбоотой талуудын эрсдэлийг бууруулдаг.

ССР-г биржийн бус зах зээл дээр үүсмэл санхүүгийн хэрэгсэл арилжих үед хэрэглэх стандарттай. Учир нь үүсмэл санхүүгийн хэрэгслийг банкнууд харилцагчдынхаа гадаад валют, зээлийн хүүгийн эрсдэлийг хедж хийхээр ашигладаг. Түүнчлэн тэтгэврийн сан, даатгалын компаниуд, хөрөнгийн менежерүүд болон санхүүгийн бус корпорацууд бэлэн мөнгөний хэлбэлзэл, хүүгийн түвшний хөдөлгөөнтэй холбоотой эрсдэлийг бууруулах зорилгоор биржийн бус зах зээл дэх үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжаанд оролцдог.

Хүснэгт. Их 20 орны ССР-г хэрэгжүүлж буй өнөөгийн байдал

ССР нэвтрүүлсэн ба дараагийн шат ахиулсан		ССР-г нэвтрүүлэх эр ажиллаж байгаа
Австрали	Солонгос	Аргентин
Бразил	Мексик	Энэтхэг
Канад	Сингапур	Индонез
Хятад	Өмнөд Африк	ОХУ
Европын холбоо	Швейцар	Саудын Араб
Хонг Конг	Турк	
Япон	АНУ	

Биржийн бус зах зээлийн арилжаанд тооцооны төвийг ажиллуулах эсэхэд зах зээлд оролцогчид болон бүтээгдэхүүнээс хамаардаг.

Биржийн бус зах зээл дээр Төвлөрсөн тооцооны төвийг үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжаанд хэрэглэдэг ба өнөөгийн манайх шиг бондын зах зээлийн арилжаанд тооцооны төв ажиллуулах нь зардал ихтэй юм.

Төвлөрсөн тооцооны төвийг ажиллуулахад хангуулах шаардлагатай шаардлагууд:

- ◆ Дефолт болох үеийн олон талын цэвэршүүлэлт хийх, арилжааны үйл явцыг явуулах, гэрээг солихын тулд хууль эрх зүйн болон эдийн засгийн нөхцөл байдлыг стандартчилах;
- ◆ Буруу сонголтоос сэргийлэхийн тулд бүтээгдэхүүн цогц бус буюу дангаараа арилжигдах;

Хүснэгт. ССР ашигладаг улсууд

Д/д	Байршил	ССР-ийн нэр
1	Австрали	ASX clear
2	Австрали	ASX clear (futures)
3	Бразил	BM&F BOVESPA ("B3")
4	Чили	ComDer
5	Хятад	Shanghai Clearing House
6	Колумб	Cámara de Riesgo Central de Contraparte de Colombia
7	Хонг Конг	OTC Clearing Hong Kong SAR
8	Энэтхэг	India Clearing Corporation Limited (CCIL)
9	Энэтхэг	NSE Clearing Limited
10	Энэтхэг	Metropolitan Clearing Corporation of India Limited
11	Япон	Japan Securities Clearing Corporation
12	Солонгос	Korea Exchange
13	Мексик	Asigna
14	ОХУ	NBCI National Clearing Centre
15	Сингапур	SGX Derivatives Clearing Ltd.
16	Өмнөд Африк	JSE Clear
17	Турк	Istanbul Settlement and Custody Bank Inc.
18	Их Британи	ICE Clear Europe Ltd.
19	Их Британи	LCH Ltd.

- ◆ Хөрвөх чадвартай бүтээгдэхүүн байх;
- ◆ Бүтээгдэхүүн нь эрсдэл үүсгэх;
- ◆ Бүтээгдэхүүний арилжих тоо хэмжээ хангалттай байх.

2009 оны Санхүүгийн хямралын дараа ББЗЗ-ийн мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх шаардлагыг тавих болсон. 2009 онд зохион байгуулагдсан G20-ийн Питтсбургийн дээд хэмжээний уулзалтын дараа хэрэгжүүлсэн эрсдэлийг бууруулах шинэчлэлийн нэг нь дэлхийн өнцөг булан бүр дэх биржийн бус зах зээлийн

(ОТС) деривативын арилжааны мэдээллийг тайлагнах байсан. Энэхүү шинэчлэл нь зах зээлийг урвуулан ашиглах /manipulation/-аас сэргийлэх, ил тод нээлттэй байх, шинээр гарч ирж буй системийн эрсдэлийг бууруулах зорилготой тул дэлхийн хэмжээнд үнэн зөв, тууштай мэдээлэгдсэн арилжааны мэдээллийг цуглуулах нь дахин санхүүгийн хямрал давтагдахаас урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдол болсон.

САНАЛ, ДҮГНЭЛТ

1. Нью-Йоркийн хөрөнгийн биржийн хувьд ОТСQX примэйртэй харьцуулахад орлогын шаардлага 2.5 дахин, олон нийт эзэмшдэг хувьцааны тоо хэмжээний шаардлага 2.2 дахин, олон нийт эзэмшиж буй хувьцааны зах зээлийн үнэлгээний шаардлага 100 дахин, 1 лот хувьцаа эзэмшдэг хувьцаа эзэмшигчдийн тооны шаардлага 4 дахин, листингд ороход тавигдах хаалтын үнийн шаардлага 4 дахин өндөр байна. Үүнээс үзэхэд Нью-Йоркийн хөрөнгийн биржид бүртгэгдэх шаардлагыг хангахад хамгийн өндөр шаардлагатай биржийн бус зах зээлийн самбар гэж үздэг ОТСQX примэйрт үнэт цаасаа гаргасан компанид хүртэл ихээхэн хол, боломжгүй мэт харагдаж байна. Иймд биржийн бус зах зээл зайлшгүй байх шаардлагатай бөгөөд том биржийн шаардлагыг хангаж үл чадах жижиг, дунд компаниуд биржийн бус зах зээлд оролцогчдын томоохон төлөөлөл болгодог.
2. Манай улсын хувьд ББЗЗ дээрх үнэт цаасны бүртгэлийн журамд үнэт цаасны шалгуур зөвхөн чанарын үзүүлэлтийг тусгасан ба бусад ББЗЗ дээрх шиг жилийн орлого, хөрөнгийн хэмжээ зэрэг тоон үзүүлэлтүүдийг нарийвчлан тусгаагүй. Иймд ББЗЗ-д үнэт цаас гаргах зорилтот бүлгийг тодорхойлоогүй харагдаж байна.
3. ББЗЗ нь зах зээл үүсгэгч гэсэн тогтолцоогоор ажилладаг ба зах зээлийн арилжаа нь дилер хоорондын болон брокероос харилцагчид гэсэн хоёр хэсэгтэй явагддаг. Зах зээлийн арилжаанд АНУ-ын мэргэжлийн болон жижиглэнгийн хөрөнгө оруулагч хоёулаа орж болдог зохицуулалттай.
4. Япон Улсын хувьд ББЗЗ-ийн үйл ажиллагааг Мэргэжлийн холбоо явуулдаг байсан бол Осакагийн хөрөнгийн биржид нэгдэж, улмаар Японы биржийн группийн дор охин компани хэлбэртэйгээр ББЗЗ нь бие даан үйл ажиллагаагаа явуулж байна. АНУ-ын хувьд ББЗЗ-ийн арилжаагаар томоохон байр суурийг эзэлдэг ба бие даасан бирж үйл ажиллагаа явуулдаг. Солонгос Улсын хувьд анх ББЗЗ үүсэхэд шинээр компани үүсгэн байгуулагдаж улмаар биржүүд нь нэгдэх үед Солонгосын биржүүдийн группэд нэгдсэн. Үүнээс дүгнэхэд ББЗЗ-ийн биржүүд биржийн групп рүү нэгдэх хандлагатай ба бие даасан бирж эсвэл мэргэжлийн холбоо уг үйл ажиллагааг эрхэлдэг байна.
5. ББЗЗ-ийн дэд бүтэц нь үнэт цаасны биржтэй адилхан бөгөөд төвлөрсөн тооцооны төв маржин арилжаа хийгддэг, санхүүгийн үүсмэл хэрэгсэл арилжигддаг нөхцөлд ажиллах зөв нөхцөл бүрддэг байна. Түүнчлэн ББЗЗ-д төвлөрсөн тооцооны төв ажиллахад бүтээгдэхүүн, үйлчилгээнд хэд хэдэн шаардлага тавьдаг байна. Иймд одоогийн манай ББЗЗ-аар зөвхөн өрийн бичиг арилжигдаж, төлбөрийг урьдчилан 100 хувь байршуулж байгаа тул тооцооны үйл ажиллагаа “Клирингийн төв” ХХК-аар дамжиж буй нь тохиромжтой.
6. Гаднын биржийн бус зах зээл дээр бонд, хувьцаа, санхүүгийн үүсмэл хэрэгсэл гэх мэт олон төрлийн бүтээгдэхүүн арилжаалагддаг. Манай зах зээлийн хувьд нэг төрлийн үнэт цаас арилжигддаг нь уг зах зээлийг бизнес эрхлэгчдэд таниулах шаардлагатайг илтгэнэ.

НАЙМ. ЭХ СУРВАЛЖ

1. Asian Bond Online. "Bond Market Guide". 2016
https://asianbondsonline.adb.org/documents/abmq/abmf_jpn_bmq2016-chp2.pdf
2. Anthony L.G., PLLC. "OTC Markets Listing Requirements". 2022
<http://www.legalandcompliance.com/securities-law/otc-market-compliance/otc-markets-listing-requirements/>
3. Cromwell Coulson. "Exploring The Fundamentals: How The OTC Markets Work". 2021
<https://blog.otcmarkets.com/2021/06/21/exploring-the-fundamentals-how-the-otc-markets-work/>
4. Financial Instruments and Exchange Act
<https://www.fsa.go.jp/common/law/fie01.pdf>
5. Finance strategists, https://learn.financestrategists.com/finance-terms/nasdaq/?_gclid=Cj0KCQjw166aBhDEARisAMEyZh5r_UcxkmbKUI2C4QHwrO21vf0qp2RnLFXzksoxQd5v2T-VpZUcl_8aAh4IEALw_wcB
6. ISDA. "OTC Derivatives: OTC Derivatives: Benefits to U.S. Companies Benefits to U.S. Companies"
<https://www.sifma.org/wp-content/uploads/2018/02/ISDA-OTC-Derivatives-Benefits-to-US-Companies.pdf>
7. INOUE Shiori, MIKI Shota* & GEMMA Yasufumi. "The Japanese Yen Interest Rate Swap Market Observed from OTC Derivative Transaction Data". 2021
https://www.boj.or.jp/en/research/wps_rev/rev_2021/data/rev21e03.pdf
8. Kawai Daisuke, Hasegawa Masaki & Yagi Risa. "An analysis of the transaction network in the Japanese OTC derivatives markets". 2021
https://www.fsa.go.jp/frtc/english/seika/srhonbun/20210707_SR_Derivative_ArticleEN.pdf
9. Investopedia, <https://www.investopedia.com/terms/i/jasdaq.asp>
10. Kiff, John, et al. "Applying the Central Clearing Mandate: Different Options for Different Markets." (2022).
11. Kim & Minki. "Korea's Over-The-Counter Market: Current State and Challenges for Revitalization". 2021
https://www.kcml.re.kr/en/publications/pub_detail_view?year=2021&zcd=002001017&zno=1620&cno=5780
12. Korea Financial Investment Association. "Market operation"
http://eng.kofia.or.kr/wpge/m_22/about/markeOperation.do
13. Kosdaq, <http://www.koreanlii.or.kr/w/index.php/KOSDAQ?ckattemp=1>
14. <http://www.legalandcompliance.com/securities-law/otc-market-compliance/otc-markets-listing-requirements/>
15. U.S. Securities and Exchange Commission. "Over-the-Counter Market". 2013
<https://www.sec.gov/divisions/marketreg/mrotc.shtml>
16. U.S. Securities and Exchange Commission. "OTC Derivatives Dealers"
<https://www.sec.gov/rules/final/34-40594.htm>
17. NYSE requirement
<https://resourcehub.bakermckenzie.com/en/resources/cross-border-listings-handbook/north-america/new-york-stock-exchange/topics/principal-listing-and-maintenance-requirements-and-procedures#:~:text=A%20company%20seeking%20to%20list,the%20most%20recent%20six%20months.>

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС

ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ КОМПАНИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

Азийн хөгжлийн банк (цаашид “АХБ” гэх)–наас Азийн эдийн засагт нөлөө бүхий улс орнуудын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани (цаашид “ТӨК” гэх)–ийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль тогтоомж, бодлого, тэдгээрийн гүйцэтгэл, хариуцлагыг дээшлүүлэхээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)–ын сүүлийн үеийн нийтлэлүүдийн үр дүнд үндэслэн “ТӨК–ийн тайлагналын ил тод байдал, хариуцлага, гүйцэтгэлийн талаар хууль, эрх зүйн зохицуулалт”–ын судалгааг 2020 онд хийжээ.

Уг судалгаанд сүүлийн жилүүдэд ТӨК–ийн хил дамнасан хөрөнгө оруулалт, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдтэй хийж буй өрсөлдөөн зэрэг нь ихээхэн анхаарал татсан асуудал болжээ. Тухайлбал, 2003 онд дэлхийн 500 ТОП компанийн 34 нь ТӨК байсан бол одоогийн байдлаар 102 болон өссөн, Азийн хөгжиж буй эдийн засагтай улс орнуудын ТОП компанид ногдох ТӨК–ийн тоо хэмжээ нэмэгдэх хандлага ажиглагдаж байгаа талаар дурджээ. ТӨК нь ихэвчлэн санхүүгийн болон үйлдвэрлэлийн чиглэлээр байгуулагдаж, тухайн салбартаа нэлээд жинг эзлэхийн зэрэгцээгээр Азийн хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээний багагүй хувийг эзлээд эхэлсэн бөгөөд тэдний дэлхийн эдийн засагт үзүүлэх нөлөөлөл нь нэмэгдэж, тухайн компанийг эзэмшигч Засгийн газрын хувьд нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлэх талаарх стандартыг сайжруулах шаардлага үүсэж байна.

ТӨК–ийн засаглал, мэдээллийн ил тод байдлын хувьд Азид төрийн өмчийн хамгийн түгээмэл загвар нь төвлөрсөн бус буюу ТӨК–ийн эзэмшлийг зохицуулах агентлаггүйгээр

салбарын яамд голчлон хэрэгжүүлдэг байсан бол сүүлийн жилүүдэд хэд хэдэн улс орны Засгийн газар төрийн өмчийг зохицуулах чиг үүргийг төвлөрүүлж, томоохон ТӨК–ийн багцад хяналт тавих төв зохицуулагч буюу холдинг компанийг бий болгох замаар бодлогын зохицуулалтыг хэрэгжүүлж эхлээд байна.

Азийн улс орнуудын төрийн өмчлөлийн хэлбэр, чиг үүргийн хувьд:



Энэтхэг: Төвлөрсөн бус тогтолцоотой буюу "зангилаа зохицуулагч" агентлагийн үүрэг гүйцэтгэгч Төрийн өмчийн аж ахуйн нэгжийн газартай. Тус газар нь ТӨК–ийн үйл ажиллагааг зохицуулах, гүйцэтгэлийг сайжруулах бодлогыг боловсруулж, салбарын яам, бусад төрийн байгууллагатай хамтран ажилладаг. ТӨК–ийн алсын хараа, эрхэм зорилго, урт, дунд, богино хугацааны зорилтуудыг салбарын яам болон Төрийн өмчийн аж ахуйн нэгжийн газартай хамтран "зөвлөлдөх хэлбэрээр" боловсруулдаг.




Индонез: Хосолмол тогтолцоотой. Төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэгч бие даасан яам байдаг бөгөөд Засгийн газар 50–иас дээш хувийн хувьцааг нь эзэмшиж, нийт 114 ТӨК–д төрийн хяналтыг хэрэгжүүлж байна.



Казахстан: Холдинг буюу төвлөрсөн тогтолцоотой. Энэ улсад бараг бүх ТӨК–ийн төлөөллийг хэрэгжүүлдэг гурван бие даасан холдинг компани байдаг. “Самрук–Казина” бол тэдний нэг бөгөөд “Бүрэн эрхт баялгийн сан” гэж нэрлэгддэг Засгийн газар 100 хувь эзэмшдэг хамгийн том хувьцаат үндэсний холдинг компани юм. Тэрээр үндэсний компаниуд болон тэдгээрийн эзэмшиж буй бусад хуулийн этгээд, охин компанид төлөөллөө хэрэгжүүлж, зохицуулдаг. ТӨК–ийн өмчлөлийн ерөнхий зорилтыг тус улсын Аж ахуйн нэгжийн хуулийн 192 дугаар зүйлд тусгасан байна.



Бүгд Найрамдах Солонгос Улс: Төвлөрсөн тогтолцоо буюу нэг яамны харьяанд зохицуулагддаг. Эдийн засаг, сангийн яам нь



Төрийн байгууллагын удирдлагын тухай хуулийн дагуу төрийн бүх байгууллагууд, тэр дундаа ТӨК-ийн өмчлөх эрхийг хэрэгжүүлдэг бөгөөд Өмчлөлийн удирдах хороо нь түүний гүйцэтгэх төлөөлөгчөөр ажилладаг аж. Үүний зэрэгцээ салбар яам бүр өөрийн үйл ажиллагааны хүрээнд хамаарах ТӨК-ийн бизнесийн үйл ажиллагаа болон нийцлийн бодлогыг хянадаг байна. Өмчлөлийн удирдах хороо нь ТӨК-ийн хяналттай холбоотой бодлогын асуудлаар шийдвэр гаргадаг. Эдийн засаг, сангийн сайдаар ахлуулсан тус хороо нь Засгийн газрын төлөөлөл, хүлээн зөвшөөрөгдсөн, мэргэшсэн гэх зэрэг 11-ээс илүүгүй гишүүний бүрэлдэхүүнтэй. Эдийн засаг, сангийн яам нь төрийн байгууллагууд, тэр дундаа ТӨК-ийн өмчлөлийг хэрэгжүүлэх дүрмийг баталж, нийтэд сурталчлах, гүйцэтгэлд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ өгөх үүрэгтэй. ТӨК-ийн үйл ажиллагааны зорилгыг тодорхойлохдоо төрийн бодлогыг харгалзан тогтоодог ба хуулийн дагуу ТӨК бүр дунд болон урт хугацааны зорилго, зорилтуудаа боловсруулж, Эдийн засаг, сангийн сайд болон холбогдох салбарын яамдад хүргүүлэх үүрэгтэй.



Малайз: Холдинг буюу төвлөрсөн тогтолцоотой. Малайз нь Засгийн газрын мэдлийн компаниудын ихэнх хувьцааны багцыг Засгийн газрын бие даасан баялгийн сан (Kazana Nasional Berhad) болон бусад хэд хэдэн томоохон холдингуудын мэдэлд байршуулсан. ТӨК-ийн бодлогын зохицуулалтыг хөнгөвчлөх зорилгоор "Мөнгөн ном" (2015) нэртэй шинэчлэлийн хөтөлбөрийг нэвтрүүлсэн байна.



Пакистан: Төвлөрсөн бус тогтолцоотой. Төрийн өмчийн төлөөллийг холбогдох салбарын зохицуулалт эрхэлсэн яамд хэрэгжүүлдэг. Төрийн өмчийн талаар тодорхой бодлого байхгүй. Ангилал, эрх зүйн хэлбэрээс хамааран ТӨК-ууд өөр өөр зохицуулалтад хамрагддаг.



Филиппин: Төвлөрсөн бус тогтолцоотой. Тусдаа зохицуулагч байгууллагатай ба ТӨК болон төрийн хяналтад байдаг бусад корпорацийн засаглалын комиссыг байгуулж, ТӨК-ийн гүйцэтгэлд хяналт тавих замаар бодлогын зохицуулалтыг тодорхой хэмжээнд баталсан. 2011 оны ТӨК-ийн Засаглалын тухай хуулиар Филиппиний Ерөнхийлөгч ТӨК-ийн эзэмшигчийн хувьд төрийн үндсэн төлөөлөгч бөгөөд

төрийн нэрийн өмнөөс ТӨК-ийн чадавхыг бэхжүүлэх үүрэг хүлээдэг ба ТӨК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийг сонгох, нэр дэвшүүлэх үйл явцад хяналт тавьж, ТӨК-ийн гүйцэтгэлийг үнэлдэг бөгөөд нийтдээ 104 ТӨК-ийг хянаж байна.



Тайланд: Төвлөрсөн тогтолцоо буюу нэг яамны удирдлага дор байдаг. Сангийн яамны харьяа Төрийн үйлдвэрийн бодлогын газар нь бүх ТӨК-д төрийн өмчийн өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлдэг бөгөөд ТӨК-д хяналт тавих үүрэгтэй ажээ.



Вьетнам: Төвлөрсөн бус тогтолцоотой буюу тус тусдаа зохицуулагч байгууллагатай. 2018 онд тус улсын 19 том ТӨК болон төрийн корпорациудад төрийн өмчийг төлөөлөх үүргийг хэрэгжүүлэхээр Төрийн хөрөнгийн удирдлагын хороо нэртэй тусгай зохицуулах байгууллагыг байгуулсан боловч төрийн өмчийн удирдлагыг салбарын яам, орон нутгийн хороод, Улсын хөрөнгө оруулалтын корпораци өөрийн эрхлэх асуудлын чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлсээр байна. Вьетнамын Үндэсний Ассамблей 2014 онд төрийн өмчийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг Улсын хөрөнгө оруулалт, менежментийн тухай хуулийг батлаад байна.

Үргэлжлэл бий...

Эх сурвалж: www.adb.org



Цахим санхүүгийн залилангаас хэрхэн сэргийлэх вэ?


Цахим санхүүгийн залилан нь компьютер, ухаалаг төхөөрөмж, нийгмийн сувгуудыг ашиглан хийгддэг хууль бус санхүүгийн гэмт хэрэг юм.

Вирус ашиглаж үйлдэх халдлага

Хувь хүний сэтгэл зүйн онцлогийг харгалзан сэдэл /мөнгө хожих, тэтгэлэг авах зэрэг/ өгч, итгэл төрүүлэн компьютерийн сүлжээнд төрөл бүрийн вирус, хортой код тараах замаар мэдээлэл цуглуулах, нууцад нэвтрэх.

Фишинг

Итгэмжлэгдсэн олон нийтийн сүлжээг дуурайн түүгээр дамжуулан хэрэглэгчийн мөнгө болон үнэт цаасны дансны мэдээлэл гэх мэт хувийн мэдээллийг олж авахыг оролддог.



Бусдын өмнөөс

мөнгө зээлэх, асуух

Таны дотны хүн, танилуудын өмнөөс эсвэл Засгийн газар, хандивын байгууллагын ажилтныг төлөөлж таныг мөнгө шилжүүлэхийг ятгадаг.

Email spoofing

И-мэйл илгээж таны хувийн мэдээллийг авах зорилготой. Таньтай утсаар, и-мэйлээр, мессенжерээр холбогдож буй хүний дугаар болон нэр буруу байдаг.

И-мэйл залилан

И-мэйлээр ирсэн зүйл нь үнэн юм шиг хэрнээ, амлалт нь хуурамч байдаг. таныг мөнгө шилжүүлэхийг, эсвэл хувийн мэдээллээ илгээхийг хүссэн байвал шалгаж үзээрэй.



Цахим санхүүгийн
залилангаас хэрхэн
өөрийгөө хамгаалдаг
юм бол...



1

Хэрэв таны харилцагч байгууллага, хувь хүнээс төлбөрийн дансны дугаар өөрчлөгдсөн гэх үндэслэлээр өөр данс руу төлбөрөө шилжүүлэхийг хүссэн цахим шуудан ирвэл энэ нь үнэн эсэхийг харилцагч талаасаа утсаар лавлах;

2

Хэрэв та онлайнаар хувийн зураг болон бичлэгээ алдсаны улмаас хэн нэгний дарамт шахалтад орж шилжүүлэг хийх гэж байгаа бол энэ талаар Цагдаагийн байгууллагад яаралтай мэдэгдэх;

3

Та сугалаанд хожсон, өв залгамжилсны улмаас их хэмжээний бэлэн мөнгө хүлээж авахаар болсон гэх мэдээллийг цахим шуудан, гар утсандаа мессежээр хүлээн авч урьдчилгаа хэлбэрээр шилжүүлэг хийх гэж байгаа бол энэ нь цахим луйврын гэмт хэрэг байж болохыг анхаараарай!

4

Цахим гэмт хэрэг үйлдэгчид адил төстэй харагдах нэр, өргөтгөл бүхий вэбсайт, цахим шуудангийн хаяг хуурамчаар үүсгэн залилан хийдэг тул Та зөвхөн вэбсайт, цахим шуудангийн мэдээллээр хязгаарлахгүй албан бичиг, утсаар холбогдох, биечлэн уулзах гэх мэт олон эх сурвалжаас сайтар баталгаажуулах.

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЧУУЛГА УУЛЗАЛТ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА.



Дэлхийн эдийн засгийн 53 дахь удаагийн чуулга уулзалт Швейцарын Давос хотод 2023 оны 01 дүгээр сарын 16–ны өдөр эхэлсэн. Чуулга уулзалтад 130 орны 2,700 гаруй

төлөөлөгч, түүний дотор 50 гаруй орны төр, засгийн тэргүүн нар оролцож, дэлхий дахинд тулгамдаж буй сорилт бэрхшээлүүдийн талаар хэлэлцсэн.

Энэ удаагийн чуулга уулзалтын хувьд бизнесийн салбарын хамгийн олон буюу 1,500 гаруй төлөөлөл оролцож байгаагаараа онцлогтой бөгөөд Засгийн газар, олон улсын байгууллагын 370 гаруй төлөөлөгч, Сангийн 56 сайд, Төв банкны 19 тэргүүн, Худалдааны 30 сайд, Гадаад хэргийн 35 сайд оролцсон.

Эдийн засгийн форум эхэлж, чуулга уулзалтаар эдийн засгийн хямралаас гадна, ОХУ–Украины мөргөлдөөн, уур амьсгалын өөрчлөлт болон дэлхий дахинд тулгамдаж буй бусад асуудлын талаар хэлэлцсэн байна.

Дэлхийн эдийн засаг

- 2023 оны эдийн засгийн өсөлтийн тухайд бизнесийн салбарын манлайлагчид эерэг таамаг дэвшүүлсэн.
- Дэлхийн улс орнууд "Ковид-19"-ийн нөхцөл байдлаас ангижирч байна.
- БНХАУ хилийн хориггоо цуцалсан нь гадаад худалдаа, аялал жуулчлалын салбар хөгжих хүчин зүйл болж байна.
- Хөгжингүй улс орнуудын Төв банкнууд инфляцыг хяналтдаа байлгахын тулд бодлогын хүүгээ өндөр байлгана гэдгээ илэрхийлсэн.

ОХУ–Украины мөргөлдөөн


- Украины тал цэргийн нэмэлт тусламж, сэргээн босголтын ажилд санхүүгийн тусламж шаардлагатай байгааг дахин мэдэгдэж, сэргээн босгох үйлст зориулсан амлалтуудыг дайн дууссаны дараа биш, харин одоо өгч эхлэх хэрэгтэй гэж үзсэн байна.

Уур амьсгалын өөрчлөлт

- Ногоон эрчим хүчийг ашиглах, энэ чиглэлд оновчтой хөрөнгө оруулалт хийх нь нэн шаардлагатай байгаа гэдэгт чуулганд оролцсон бүх хүмүүс санал нэгдсэн байна.
- Бизнесийн салбарын манлайлагчид, хөгжингүй улс орнууд, томоохон корпорацууд уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх чиглэлээр илүү их хөрөнгө оруулалт хийнэ гэдгээ илэрхийлсэн.

www.globalnews.ca

ДЭЛХИЙН ЭРСДЭЛИЙН ТАЙЛАН ГАРАВ.



Дэлхийн Эдийн Засгийн Форум /WEF/-аас 2023 онд үүсэж болох эрсдэлийн тайланг танилцуулсан байна. WEF жил бүр ирэх онд үүсэж болох эдийн засаг, хүрээлэн буй орчин, нийгэм, технологи, улс төрийн гэх 5 ангиллын эрсдэлүүдийг зарладаг. Энэ удаад амьжиргааны өртгийн хямрал болон худал

мэдээлэл гэх 2 шинэ үзүүлэлтийг нэмсэн байна.

Тус тайлангаас харахад ойрын 2 жилд улс орнуудад амьжиргааны зардлын өсөлт, байгалийн гамшигт үзэгдэл болон эдийн засгийн зөрчилдөөн нэн тулгамдсан асуудал болох аж. Иймд улс орон хоорондын эдийн засгийн хориг арга хэмжээ ихсэж, улмаар худалдааны дайн ч гарах магадлалтай байна.

Харин урт хугацаанд буюу 10 жилийн дараагаас уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн гарах эрсдэлүүд эрс нэмэгдсэн байдалтай байна.

https://www3.weforum.org/docs/WEF_Global_Risks_Report_2023.pdf

ДЭЛХИЙН 2023 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ТААМАГЛАЛ

1. JPMorgan Chase & Co



“Санхүүгийн хатуу нөхцөл байдал, АНУ-ын төсвийн дэмжлэг багатай бодлого, геополитикийн тодорхойгүй байдал, өрхийн худалдан авах чадвар алдагдсан зэргээс шалтгаалан хөгжингүй улс орнуудын эдийн засаг 2023 онд бага зэргийн уналтад орно” гэж шинжээчид үзэж байна.

Төв банкнуудын зорилтот түвшнээс дээгүүр хэвээр байгаа хэдий ч эдийн засаг удааширч, хөдөлмөрийн зах зээл суларч, нийлүүлэлтийн хэлхээний дарамт багассаар, Европ эрчим хүчний хангамжаа төрөлжүүлж байгаа тул инфляц бага зэрэг буурч эхлэх хандлагатай байна.

www.am.jpmorgan.com



2. Олон улсын валютын сан – IMF

“Дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт ОХУ-Украины дайн үргэлжилж, инфляц өндөр байгаагийн улмаас сул хэвээр байх төлөвтэй байна” хэмээн ОУВС-н тайланд дурдсан байна.

ОУВС нь Дэлхийн эдийн засгийн өсөлтийг 2022 оны 10 дугаар сард 2.7 хувиар өснө гэж таамаглаж байсан бол тус таамаглалаа 0.2 пунктээр өсгөж, 2.9 хувиар өснө гэж таамаглалаа ахиулсан байна.

www.aa.com.tr/en



3. Нэгдсэн Үндэстний Байгууллага – UN

НҮБ Украины дайнаас үүдэлтэй хүнс, эрчим хүчний хямрал, Ковид-19 цар тахлын нөлөөлөл, өндөр инфляц, уур амьсгалын онцгой байдал зэргийг харгалзан

дэлхийн эдийн засгийн өсөлтийн энэ оны төсөөллөө огцом бууруулж, 1.9 хувьд хүргэлээ.

Тайланд дурдсанаар, 2023 онд дэлхийн эдийн засаг 3.0 хувиар өснө гэж таамаглаж байсан 2022 оны төсөөллийг бууруулж, 1.9 хувьд хүргэсэн нь сүүлийн олон арван жилийн түүхэн дэх хамгийн сул үзүүлэлт болжээ.

НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн мэдээлснээр, “Одоогийн дэлхийн эдийн засгийн удаашрал нь хөгжингүй болон хөгжиж буй орнуудыг хамарч, 2023 онд эдийн засгийн уналтад орох олон эрсдэлтэй тулгарна” гэж үзсэн байна. Тодруулбал, АНУ, Европын холбоо болон бусад хөгжингүй улс орнуудын өсөлтийн эрч суларснаар, дэлхийн бусад улс орнуудын эдийн засагт сөргөөр нөлөөлнө гэж таамаглажээ.


www.cnn.com

ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2023 оны 02 дугаар сарын 29-ны өдөр

S&P 500 /[^]GSPC/


3,970.15 -12.09 (-0.03%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

Nikkei 225 /[^]N225/


27,445.56 +21.60 (+0.08%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

FTSE 100 /[^]FTSE/


7,876.30 -58.80 (-0.74%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

NASDAQ Composite ([^]IXIC)

11,455.54 -11.44 (-0.10%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC_of_Mongolia